



ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

ИННОВАЦ, ТЕХНОЛОГИЙН ПАРК БАЙГУУЛАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН



УЛААНБААТАР ХОТ
2024 он

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

**ИННОВАЦ, ТЕХНОЛОГИЙН
ПАРК БАЙГУУЛАХ СУДАЛГААНЫ
ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН

ГАРЧИГ**НЭГ.НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ**

1.	Макро эдийн засгийн шинжилгээ	3
2.	Дотоодын нийт бүтээгдэхүүн, орлогын аргаар	4
3.	Үндсэн үзүүлэлтүүд, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар	6
4.	Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэд	12
5.	НДШ төлөлтийн тайланд хамрагдсан даатгуулагчид	13

ХОЁР.ГАДНЫН УЛС ОРНУУДЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ПАРК БАЙГУУЛСАН ТҮҮХЭН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

6.	ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА	
7.	АНУ-ын ШУТП-ын туршлага	19
8.	“Alliance” парк	20
9.	“Иова” парк	22
10.	“Regensburg” технологийн парк	23
11.	Берлин Адлерсхофын ШУТ-ын Парк (WISTA)	24
12.	БНХАУ-ын паркийн туршлагаас	27
13.	Шанхай хотын Боашань парк	27
14.	Шанхай хотын Технологийн парк	28
15.	Циндаогийн шинжлэх ухааны парк	30
16.	Шэнжэний инновац, технологийн парк	32
17.	Тайваны шинжлэх ухааны парк	34
18.	Латви улс - Даугавпилс технологийн парк	39
19.	Рига аж үйлдвэрийн парк	39
20.	Финланд улс - Турку шинжлэх ухааны парк	40
21.	БНСУ-ын ШУП-ийн туршлагаас	41
22.	Даедок Иннополис	41

23.	Улсан дахь үйлдвэрийн парк	42
24.	Словений Любляна паркийн туршлагаас	43
25.	Израиль улс – Силикон Вади	43
26.	Олон улсын туршлагаас монгол улсад Хэрэгжүүлэх сургамж ба туршлага	50

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ,
ИННОВАЦЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

27.	Салбарын хууль эрх зүйн орчин	55
28.	Шинжлэх ухаан, технологи, инновацын парк гэж юу вэ?	60
29.	Парк хоорондын ялгаа	64
30.	Үндэслэл, хэрэгцээ шаардлага	68

ДӨРӨВ. ПАРК ДАХЬ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ХЭМЖЭЭ, ХУДАЛДААНЫ ЭРГЭЛТИЙН ТААМАГЛАЛ

31.	Паркийн амжилтын чухал хүчин зүйлсийн тодорхойлолт	72
32.	Нийгэм эдийн засгийн үр нөлөө	74
33.	Таамаглал	76
34.	Ерөнхий дүгнэлт	78

НЭГ.НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ


Макро эдийн засгийн шинжилгээ:

Монгол улсын Үндсэн хуульд төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулахаар тунхагласан. Монгол улс нь бага-дунд орлоготой, далайд гарцгүй, байгалийн баялаг ихтэй, шилжилтийн шатанд яваа нээлттэй эдийн засаг бүхий улс юм.


Дэлхийн санхүү эдийн засгийн хүндрэл, уул, уурхай олборлох салбарын түүхий эдийн үнийн тасралтгүй уналт болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралт зэргээс шалтгаалан 2012- 2016 онуудад эдийн засгийн өсөлт 12.3-1.2 хувь хүртэл буурсан. Сүүлийн жилүүдэд эдийн засаг аажмаар сэргэж, 2017-2018 онуудад 5.3-7.2 хувиар өссөн бол 2019 онд эдийн засгийн өсөлт 5.1 хувь болж, өмнөх онтой харьцуулахад 2.1 пунктээр буурсан байна.

2024 оны эхний хагас жилийн байдлаар уул уурхайн салбар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.4 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийн 1.8 нэгж хувийг бүрдүүлсэн. Үүнд зэсийн баяжмал үйлдвэрлэл, нүүрс болон төмрийн хүдрийн олборлолт тогтвортой нэмэгдсэн нь голлон нөлөөлөв. Мөн уул уурхайн экспортын тээвэр, бараа бүтээгдэхүүний импорт, дамжин өнгөрөх тээвэр нэмэгдсэнээр тээврийн салбар 27.4 хувиар тэлж, өсөлтийн 1.0 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Аж үйлдвэр, барилгын салбар 7.9 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийн 0.8 нэгж хувийг бүрдүүлэв. Барилгын салбарын бүтээн байгуулалт, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл тус салбарын үйлдвэрлэлд эергээр нөлөөлсөн. Худалдаа, үйлчилгээний салбарууд (тээврээс бусад) 7.8 хувиар тус өсөж, эдийн засгийн өсөлтийг 4.4 нэгж хувиар нэмэгдүүлсэн байна. Харин хөдөө


аж ахуйн салбар өвөлжилт, хаваржилтын хүндрэлийн улмаас 26.7 хувиар агшиж, өсөлтийг 3.9 нэгж хувиар хязгаарласан байна.



ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, орлогын аргаар



НЭГ ХҮНД НОГДОХ ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2022 I-VI	2023 I-VI	2024 I-VI
Ердийн цэвэр өсөлт	1000 хүнд ногдох	▼ 6.2 ^{-2.1}	▲ 7 ^{0.8}	▼ 5.9 ^{-1.1}
Төрөлт	1000 хүнд ногдох	▼ 8.8 ^{-2.0}	▲ 9.5 ^{0.7}	▼ 8.4 ^{-1.1}
Нас баралт	1000 хүнд ногдох	▲ 2.6 ^{0.1}	▼ 2.5 ^{-0.1}	2.5 ^{0.0}
Нийгмийн даатгалын сангийн орлого	тэрбум төгрөг	▲ 1 636.1 ^{22.4}	▲ 1 917.3 ^{17.2}	▲ 2 668.9 ^{39.2}
Нийгмийн даатгалын сангийн зарлага	тэрбум төгрөг	▲ 1 626.1 ^{18.1}	▲ 1 821.5 ^{12.0}	▲ 2 446.6 ^{34.3}
Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ	тэрбум төгрөг	▲ 1 591.0 ^{27.4}	▲ 1 773.0 ^{11.4}	▲ 2 434.6 ^{37.3}
Нийгмийн даатгалд даатгуулагчид	мянган хүн	▲ 1 029.9 ^{7.0}	▲ 1 061.1 ^{3.0}	▼ 927.4 ^{-12.6}
Нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ	тэрбум төгрөг	▲ 1 015.0 ^{1.3}	▼ 971.9 ^{-4.2}	▲ 1 158.2 ^{19.2}
Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан хүн	мянган хүн	▲ 2 291.6 ^{0.3}	▼ 2 262.0 ^{-1.3}	▲ 2 432.8 ^{7.6}
Амьд төрсөн хүүхэд	хүн	▼ 30 220 ^{-17.4}	▲ 33 004 ^{9.2}	▼ 28 846 ^{-12.6}
Амаржсан эх	хүн	▼ 30 044 ^{-17.3}	▲ 32 805 ^{9.2}	▼ 28 635 ^{-12.7}
Нас баралт	хүн	▲ 8 816 ^{5.3}	▼ 8 613 ^{-2.3}	▼ 7 215 ^{-16.2}
Эмнэлэгт нас барсан	хүн	▲ 2 658 ^{0.2}	▲ 2 702 ^{1.7}	▼ 2 316 ^{-14.3}
Эндсэн эх	хүн	▼ 3 ^{-81.3}	▼ 1 ^{-66.7}	▲ 4 ^{4.0**}
Нялхсын эндэгдэл	хүн	▼ 385 ^{-5.6}	▲ 415 ^{7.8}	▼ 304 ^{-26.7}
Нялхсын эндэгдлийн түвшин	1000 амьд төрөлтөд ногдох	▼ 12 ^{-1.0}	12 ^{0.0}	▼ 11 ^{-1.0}
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	хүн	▲ 493 ^{3.1}	▼ 498 ^{1.0}	▼ 383 ^{-23.1}
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин	1000 амьд төрөлтөд ногдох	▲ 16 ^{1.0}	▼ 16 ^{0.0}	▼ 13 ^{-3.0}
Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид	мянган хүн	▲ 542.4 ^{51.9}	▲ 542.7 ^{0.1}	▼ 533.3 ^{-1.7}
Халдварт өвчнөөр өвчлөгчид	хүн	▲ 256 852 ^{2.1**}	▼ 25 270 ^{-90.2}	▼ 20 126 ^{-20.4}
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	▲ 20 125 ^{89.9}	▼ 19 122 ^{-5.0}	▲ 20 507 ^{7.2}
16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	▲ 93 ^{44.0}	▼ 87 ^{-6.0}	▲ 92 ^{5.0}
Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ	тэрбум төгрөг	▲ 167.3 ^{95.4}	▲ 194.0 ^{16.0}	▲ 290.7 ^{49.8}
Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт	тэрбум төгрөг	▲ 95.0 ^{2.4**}	▲ 98.5 ^{3.7}	▼ 89.0 ^{-9.6}
Бүртгэгдсэн гэмт хэрэгт холбогдсон нийт яллагдагчид	хүн	▲ 12 411 ^{66.2}	▼ 11 714 ^{-5.6}	▼ 10 436 ^{-10.9}
18 хүртэлх насныхан	хүн	▲ 808 ^{2.7**}	▼ 740 ^{-8.4}	▼ 737 ^{-0.4}

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар


Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2022 I-VI	2023 I-VI	2024 I-VI
Гүйлгээнд гарсан бэлэн мөнгө, сарын эцэст	тэрбум төгрөг	▼ 1 034.9 ^{-11.8}	▲ 1 098.5 ^{6.1}	▲ 1338.2 ^{21.8}
M1, сарын эцэст	тэрбум төгрөг	▲ 6 067.1 ^{1.5}	▲ 8 281.3 ^{36.5}	▲ 11804.3 ^{42.5}
M2, сарын эцэст	тэрбум төгрөг	▼ 27 635.5 ^{-1.2}	▲ 31 438.5 ^{13.8}	▲ 41420.3 ^{31.8}
Зээлийн өрийн үлдэгдэл, сарын эцэст	тэрбум төгрөг	▲ 19 159.0 ^{10.3}	▲ 23 471.3 ^{22.5}	▲ 33 486.5 ^{42.7}
Анхаарал хандуулах зээл, сарын эцэст	тэрбум төгрөг	▼ 1 104.2 ^{-7.2}	▲ 1 325.4 ^{20.0}	▼ 1235.3 ^{-6.8}
Чанаргүй зээл, сарын эцэст	тэрбум төгрөг	▲ 2 101.8 ^{7.4}	▲ 2 214.1 ^{5.3}	▼ 1957.2 ^{-11.6}
Гадаад валютын нэрлэсэн ханш, сарын дундаж: АНУ доллар	төгрөг	▲ 3 124.25 ^{9.7}	▲ 3 438.26 ^{10.1}	▼ 3381.11 ^{-1.7}
Евро	төгрөг	▼ 3 303.46 ^{-3.7}	▲ 3 727.66 ^{12.8}	▼ 3640.02 ^{-2.4}
Юань	төгрөг	▲ 466.84 ^{5.3}	▲ 479.83 ^{2.8}	▼ 466.05 ^{-2.9}
Рубль	төгрөг	▲ 55.37 ^{41.0}	▼ 41.07 ^{-25.8}	▼ 38.5 ^{-6.3}
Валютын хадгаламж, сарын эцэст	тэрбум төгрөг	▲ 4 526.4 ^{3.7}	▲ 5 195.9 ^{14.8}	▼ 4601.3 ^{-11.4}
Арилжсан үнэт цаас	мянган ширхэг	▼ 154 113.0 ^{-57.6}	▲ 861 609.4 ^{5.6**}	▼ 785 313.3 ^{-8.9}
Үнэт цаасны гүйлгээ	тэрбум төгрөг	▼ 246.6 ^{-60.2}	▲ 512.9 ^{2.1**}	▲ 797.08 ^{55.4}
Үнэт цаасны зах зээлийн ТОП-20 дундаж индекс, сарын эцэст	нэгж	▲ 33 867.2 ^{2.6}	▲ 36 476.1 ^{7.7}	▲ 43080.3 ^{18.1}
Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламж	тэрбум төгрөг	▲ 8 001.5 ^{12.6}	▲ 11 059.2 ^{38.2}	▲ 14 947.2 ^{35.2}
Улсын төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ	тэрбум төгрөг	▼ 5 055.1 ^{-4.4}	▲ 7 713.0 ^{52.6}	▲ 10 504.2 ^{36.2}
Орон нутгийн нийт орлого, тусламжийн хэмжээ	тэрбум төгрөг	▼ 1 292.1 ^{-28.7}	▲ 1 924.8 ^{49.0}	▲ 3,196.30 ^{66.1}
Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага болон эргэж төлөгдөх цэвэр зээл	тэрбум төгрөг	▲ 8 191.9 ^{9.3}	▲ 9 033.8 ^{10.3}	▲ 12 911.3 ^{42.9}
Улсын төсвийн нийт зарлага болон цэвэр зээл	тэрбум төгрөг	▼ 5 063.5 ^{-16.9}	▲ 6 443.5 ^{27.3}	▲ 9 407.2 ^{46.0}
Орон нутгийн нийт зарлага болон цэвэр зээл	тэрбум төгрөг	▼ 950.9 ^{-27.9}	▲ 1 234.5 ^{29.8}	▲ 2 535.2 ^{2.1**}
Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	тэрбум төгрөг	▼ 844.0 ^{-21.1}	▲ 1 032.7 ^{22.4}	▲ 1 287.5 ^{24.7}
Гадаад худалдааны нийт эргэлт	сая америк доллар	▲ 9 257.1 ^{26.2}	▲ 11 827.0 ^{27.8}	▲ 13 264.6 ^{12.2}
Экспорт	сая америк доллар	▼ 5 309.1 ^{-24.6}	▲ 7 564.4 ^{42.5}	▲ 7 886.2 ^{4.3}
Импорт	сая америк доллар	▼ 3 948.0 ^{21.0}	▲ 4 273.6 ^{8.2}	▲ 5 378.4 ^{25.9}
Гадаад худалдааны тэнцэл	сая америк доллар	▲ 1 361.0 ^{67.8}	▲ 3 290.8 ^{2.4**}	▼ 2 507.7 ^{-23.8}
Хэрэглээний үнийн индекс (өмнөх сартай харьцуулсан)	хувь	▲ 1.5 ^{66.7}	▼ 1.0 ^{-33.3}	▼ 0.3 ^{-70.0}
Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны мөн үетэй харьцуулсан)	хувь	▲ 16.9 ^{2.5**}	▼ 10.6 ^{-37.3}	▼ 5.1 ^{-51.9}
Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны эцэстэй харьцуулсан)	хувь	▲ 9.5 ^{35.7}	▼ 7.1 ^{-25.3}	▼ 4.3 ^{-39.4}
Статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй ААНБ	мянган ААНБ	▲ 237.5 ^{11.0}	▲ 254.9 ^{7.3}	▼ 245.7 ^{-3.6}
Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага	мянган ААНБ	▲ 83.5 ^{6.5}	▲ 89.4 ^{7.1}	▲ 99.1 ^{10.9}

ДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2022 I-VI	2023 I-VI	2024 I-VI
Мал төллөлт	мянган толгой	▲ 24 891.6 ^{20.0}	▼ 21 049.8 ^{-15.4}	▼ 16 958.3 ^{-19.4}
Төл бойжилт	мянган толгой	▲ 24 452.3 ^{23.2}	▼ 18 025.2 ^{-26.3}	▼ 15 414.8 ^{-14.5}
Зүй бусаар хорогдсон том мал	мянган толгой	▼ 218.1 ^{-90.9}	▲ 3 886.5 ^{17.8**}	▲ 8086.4 ^{2.1**}
Өвчнөөр хорогдсон мал	мянган толгой	▼ 13.2 ^{-8.3}	▲ 53.0 ^{4.0**}	▼ 8.8 ^{-83.4}
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл	тэрбум төгрөг	▼ 8 670.1 ^{-3.4}	▲ 13 373.1 ^{54.2}	▲ 15 571.3 ^{16.4}
Уул уурхай, олборлолт	тэрбум төгрөг	▼ 5 508.8 ^{-10.9}	▲ 9 249.5 ^{67.9}	▲ 11 198.0 ^{21.1}
Боловсруулах үйлдвэрлэл	тэрбум төгрөг	▲ 2 319.7 ^{15.3}	▲ 3 044.1 ^{31.2}	▲ 3 181.1 ^{4.5}
Цахилгаан, хий уур агааржуулалт	тэрбум төгрөг	▲ 749.0 ^{5.6}	▲ 970.0 ^{29.5}	▲ 1 053.1 ^{8.6}
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	тэрбум төгрөг	▲ 92.6 ^{19.9}	▲ 109.5 ^{18.3}	▲ 139.1 ^{27.0}
Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн	тэрбум төгрөг	▼ 11 698.7 ^{-4.6}	▲ 21 643.8 ^{85.0}	▲ 25 657.8 ^{18.5}
Уул уурхай, олборлолт	тэрбум төгрөг	▼ 8 049.7 ^{-9.5}	▲ 16 645.6 ^{2.1**}	▲ 20 697.5 ^{24.3}
Боловсруулах үйлдвэрлэл	тэрбум төгрөг	▲ 2 804.2 ^{8.7}	▲ 3 914.4 ^{39.6}	▼ 3 762.8 ^{-3.9}
Цахилгаан, хий уур агааржуулалт	тэрбум төгрөг	▲ 750.2 ^{5.7}	▲ 970.9 ^{29.4}	▲ 1 052.8 ^{8.4}
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	тэрбум төгрөг	▲ 94.6 ^{17.5}	▲ 113.0 ^{19.5}	▲ 144.8 ^{28.1}
Төмөр замын тээврийн орлого	тэрбум төгрөг	▼ 325.3 ^{-17.2}	▲ 526.8 ^{61.9}	▲ 594.9 ^{12.9}
Төмөр замаар тээсэн ачаа	мянган тонн	▼ 12 661.9 ^{-20.5}	▲ 15 873.8 ^{25.4}	▲ 16 439.3 ^{3.6}
Төмөр замын тээврээр зорчигчид	мянган хүн	▲ 1 045.8 ^{3486.0**}	▲ 1 074.9 ^{2.8}	▼ 996.2 ^{-7.3}
Агаарын тээврийн орлого	тэрбум төгрөг	▲ 149.5 ^{2.1**}	▲ 358.0 ^{2.4**}	▲ 444.3 ^{24.1}
Агаарын тээврээр тээсэн ачаа	тонн	▲ 6 452.8 ^{3.3**}	▼ 4 077.7 ^{-36.8}	▲ 4 598.4 ^{12.8}
Агаарын тээврээр зорчигчид	мян. хүн	▲ 323.5 ^{5.5**}	▲ 708.3 ^{2.2**}	▲ 929.9 ^{31.3}
Улсын хилээр нэвтэрсэн нийт зорчигчид				
орсон	мян. хүн	▲ 289.4 ^{72.2}	▲ 1059.1 ^{3.7**}	▲ 1547.2 ^{46.1}
гарсан	мян. хүн	▲ 285.5 ^{76.3}	▲ 1058.5 ^{3.7**}	▲ 1524.1 ^{44.0}

** Дахин их


у* - х нь өмнөх оны мөн үетэй харьцуулсан цэвэр өсөлт, бууралтын хувь





ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, 2024 оны 2 дугаар улиралд

Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд



Ажил мэргэжлийн ангиллаар





Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаад иргэд 15.6 мянга болж, өмнөх улирлаас 92.9 хувиар өсөж, гадаадад хөдөлмөр эрхлэхээр 265 иргэн зуучлагдаж, өмнөх улирлаас 18.2 хувиар буурсан байна.


Манай улсад 2024 оны 2 дугаар улирлын байдлаар гадаадын 102 улсын 15.6 мянган иргэн хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлс, орлого олох зорилготойгоор хөдөлмөр эрхэлж, мөн цалин хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байна. Ажил эрхэлж буй гадаад иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 4.4 (39.2%) мянган хүнээр, өмнөх улирлаас 7.5 (92.9%) мянган хүнээр тус тус өссөн байна. Ажил эрхэлж буй гадаад иргэдийн 14.4 (92.3%) мянга нь эрэгтэй, 1.2 (7.7%) мянга нь эмэгтэй байна.

Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаад иргэдийн 71.1 хувь нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын, 7.6 хувь нь Бүгд Найрамдах Энэтхэг Улсын, 3.9 хувь нь Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын, 2.7 хувь нь Бүгд Найрамдах Турк Улсын, 2.1 хувь нь Оросын Холбооны Улсын, 1.9 хувь нь Бүгд Найрамдах Филиппин Улсын, 1.7 хувь нь Бүгд Найрамдах Солонгос Улсын, 1.5 хувь нь Америкийн Нэгдсэн Улсын, 7.5 хувь нь бусад улсын харьяат байна.

Насны бүлгээр харьцуулбал 35-39 насныхан хамгийн их буюу 2.7 (17.1%) мянган хүн, 20 хүртэлх насныхан хамгийн бага буюу 151 (1.0%) хүн байна.

1

АЖИЛ ЭРХЭЛЖ БАЙГАА ГАДААДЫН ИРГЭД, насны бүлгээр, хүйсээр, 2024 оны 2 дугаар улирлын байдлаар




Монгол Улсаас хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлстэй ажил эрхлэхээр Бүгд Найрамдах Солонгос улс руу 190, Япон улс руу 75, нийт 265 хүн 2024 оны 2 дугаар улиралд зуучлагдсан нь өмнөх улирлаас 59 (18.2%) хүнээр буурсан байна. Хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлстэй ажил эрхлэхээр зуучлагдсан иргэдийн 158 (59.6%) нь эрэгтэй, 107 (40.4%) нь эмэгтэй байна.

Хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлстэй ажил эрхлэхээр зуучлагдсан иргэдийн хамгийн их буюу 29.8 хувь нь 25-29 насныхан, хамгийн бага буюу 1.5 хувь нь 45-49 насныхан байна.

¹ Үндэсний статистикийн хороо, 1212.mn

ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР ГАДААД УЛСАД ЗУУЧЛАГДСАН ИРГЭД

насны бүлэг, хүйс, 2024 оны 2 дугаар улирлын байдлаар



Хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлстэй ажил эрхлэхээр зуучлагдсан 265 иргэдийн 119 (44.9%) нь бакалаврын болон дипломын дээд, 104 (39.3%) нь бүрэн дунд, 26 (9.8%) нь тусгай мэргэжлийн дунд, 16 (6.0%) нь техникийн болон мэргэжлийн боловсролтой байна.

Хөдөлмөрийн гэрээгээр зуучлагдсан иргэдийн 199 (75.1%) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 34 (12.8%) нь хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа, 19 (7.2%) нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт, 8 (3.0%) нь барилгын салбарт, 5 (1.9%) нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт зуучлагджээ.




АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, 2024 оны 1 дүгээр улиралд



Цалин хөлсний бүлгээр, дүнд эзлэх хувиар

Ажиллагчид




Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд 2024 оны эхний улирлын байдлаар нийт 50.2 мянган аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ)-ын 753.4 мянган ажиллагч хамрагдсан байна.

Нийгмийн даатгалын шимтгэл (НДШ) төлсөн ААНБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 924 (1.9%)-өөр өсөж, өмнөх улирлаас 861 (1.7%)-ээр буурсан бол ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 16.6 (2.2%) мянгаар өсөж, өмнөх улирлаас 17.7 (2.3%) мянгаар буурчээ.

НДШ ТӨЛӨЛТИЙН ТАЙЛАНД ХАМРАГДСАН ДААТГУУЛАГЧИД

эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, жил бүрийн эхний улирлын байдлаар



**ХОЁР.ГАДНЫН УЛС ОРНУУДЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ПАРК БАЙГУУЛСАН
ТҮҮХЭН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ****Гадаад орнуудын туршлага**

Шинжлэх ухааны парк байгуулах, түүнийг урт удаан хугацаанд тогтвортой ажиллуулахын тулд амжилттай ажилласан болон амжилтгүй болсон паркуудын туршлагыг судлах нь зүйтэй.

Шинжлэх ухааны парк нь бүс нутгийн түүхий эд, хүний нөөцөд тулгуурлан хүчирхэгжих зорилготой бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ, шинжлэх ухааны судалгаа шинжилгээ болон технологийн хөгжлийг үйлдвэрлэлд нэвтрүүлдэг, дангаараа эдийн засгийн үйл ажиллагаа явуулах чадамж бүхий хязгаарлагдсан нутаг дэвсгэр бөгөөд хотын төвлөрсөн суурьшлын бүсээс зайдуу, хатуу хучилттай болон төмөр зам, агаарын тээврийн систем сайн хөгжсөн хэсэгт голчлон байрладаг онцлогтой.

Хүснэгт 1. Паркийн хөгжлийн явц

Он	Төвлөрөл	Удирдлага
1970-аад оны эхэн үе	Үйлдвэрлэл	Төр, засгийн газрын харьяа байгууллага
1970 - 1980	Үйлдвэрлэл + бизнес + техник технологи	Төрийн өмчийн болон хувийн компаниуд
1990-ээд он эхэн үе	Үйлдвэрлэл + бизнес + техник технологийн ололт амжилт + үйлчилгээ	Төрийн өмчийн болон хувийн компаниуд+ судалгааны байгууллага

1990-ээд оны сүүл үе	Шинэ дэвшилтэт технологи + шинжлэх ухаан, R&D + үйлчилгээ, тав тухтай амьдрах орчин	Төрийн өмчийн болон хувийн компаниуд+ судалгааны байгууллага, их сургууль + хөрөнгө оруулагчид
2000-аад оны үе	Шинжлэх ухаан + инноваци + үйлчилгээ, тав тухтай амьдрах орчин + ногоон байгаль	Төрийн өмчийн болон хувийн компаниуд+ судалгааны байгууллага, их сургууль + хөрөнгө оруулагчид

Олон улсын судалгаанаас үзэхэд паркуудыг дараах байдлаар ерөнхийлөн ангилна.

- Паркийн үйл ажиллагааны төрөлжилт – шинжлэх ухааны парк, судалгааны парк, эко-үйлдвэрлэлийн парк;
- Өмчийн эзэмшигч – төрийн, хувийн өмчийн, төр-хувийн хамтын өмчийн;
- Газар – дахин төлөвлөлт хийсэн парк буюу “brown”, шинэ газар шинээр парк байгуулж байвал “green”;

Паркийн үйл ажиллагааны төрөлжилт талаас нь харвал дараах төрлийн паркийн ангилал зонхилох хандлагатай байна. Үүнд:

- **Аж үйлдвэрийн парк.** Том үйлдвэрлэл голлосон агуулах, логистикийн төвүүд бүхий цогцолбор;
- **Агуулах хангамжийн парк.** Тээврийн хэрэгслэлийг ачиж буулгах терминалууд, тээврийн хэрэгслийн зогсоол бүхий төрөлжсөн агуулах, бөөний худалдааны төв бүхий цогцолбор. Зочид буудал, оффис, бусад үйлчилгээг багтаасан дагалдах дэд бүтцийн нэгжүүд байж болно.

- **Логистик парк.** Том хэмжээний бүрэн механикжсан, автоматчилагдсан агуулах, агуулахуудын орчинд логистикийн оролцоог нэмэгдүүлж, бүх төрлийн үйлчилгээг явуулах, олон улсын болон дотоодын бөөний худалдааны цогцолбор;
- **Шинжлэх ухааны парк.** Өндөр технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх лаборатори, гарааны компани, энтрепренэрийг хөгжүүлэх цогцолбор байна;
- **Инновац, технологийн парк.** Инновацид суурилсан өндөр технологийн компаниудыг багтаасан парк юм. Энэ нь их сургууль, судалгаа хөгжлийн төвүүдийг түшиглэх нь олонтаа;
- **Инкубатор парк.** Жижиг, дунд үйлдвэрүүдийн хөгжлийн орчинг бүрдүүлэхэд чиглэсэн гараагаа эхэлж байгаа үйлдвэрлэгчдийг хамруулсан зохион байгуулалтын хэлбэр юм. Засгийн газар, бүс нутгийн удирдлагаас тухайн орон нутгийн эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд уг паркийн зохион байгуулалтыг ашигладаг байна. Мөн холимог парк буюу судалгааны болон технологийн паркийн бүтцийн хэсэг, дэмжих нэгж байдлаар инкубатор паркийг хөгжүүлж болно;

Corporate парк. Одоогоор Хөгжингүй улсуудад л байгаа паркийн хөгжил хувьслын хамгийн орчин үеийн хэлбэр. Өндөр хөгжлийн суурьшлын бүсэд (*том хотод голчлон байдаг*) байрлах бөгөөд томоохон хэмжээний оффисууд, судалгааны төв, авсаархан хэмжээний үйлдвэрлэл, худалдааны төв, амралт чөлөөт цагт зориулсан үйлчилгээ, зочид буудал, хурал, үзэсгэлэнгийн төв бүхий том хотын тухайн тодорхой бүсэд төвлөрсөн цогцолбор юм;

Сүүлийн үед “Эко-парк” гэх нэр томъёо ихээр хэрэглэгдэх болсон нь агаарын бохирдлыг бууруулах, тээврийн автозамын ачааллыг бууруулах, хог хаягдлыг багасгах, дахин боловсруулах зэрэг асуудлыг шийдвэрлэх

зорилготой юм. Өөрөөр хэлбэл “Эко- парк” нь бизнесийн ашиг орлоготой төдийгүй нийгмийн хариуцлагатай байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийн парк юм.

Паркууд нь зохион байгуулагдах үйл ажиллагаанаасаа хамаарч дараах хэлбэртэй байж болно. Үүнд:

- **Холимог:** Өөр хоорондоо технологийн шууд харилцан уялдаагүй үйлдвэрлэл явуулдаг жижиг ба дунд үйлдвэрлэлээс бүрдсэн бүтэцтэй.
- **Дагнасан:** Нэг том үйлдвэрт ханган нийлүүлэлт хийдэг олон жижиг, дунд үйлдвэрүүдээс бүрдсэн.
- **Түрээсийн буюу тенант хэлбэрийн:** Хүмүүсийг ажлын байраар хангах үйлчилгээний төрлийн бизнес бүхий өрхийн үйлдвэрлэлийг нэг байршилд төвлөрүүлэн ажлын байр, орон сууцны асуудлыг нэг шийдэх боломжтой жижиг бизнесийг төвлөрүүлсэн. Ийм паркийг бизнесийн инкубаторын хэлбэрээр байгуулж, ядуурлыг бууруулах олон төрлийн хөтөлбөрийн хөрөнгийг нэгтгэн үр дүнтэй ашиглахаар зохион байгуулна.
- **Бусад:** Өөр хоорондоо үйлдвэрлэл, технологийн харилцан хамааралтай болон хамааралгүй үйлдвэрүүдээс бүрдсэн парк тус тус болно.

Шинжлэх ухааны паркийн өрсөлдөх чадварын гол үзүүлэлт нь бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортын түвшин бөгөөд тухайн бүс нутаг, аймаг, хот нь доор дурдсан давуу талуудтай байх шаардлагатай.

- Газар зүйн тохиромжтой байршил;
- Нөөц болон түүхий эдэд ойр дөт байдал;
- Дэд бүтцийн хангамж сайн, эсвэл ойрын хугацаанд сайжрах боломжтой;

- Шууд хөрөнгө оруулалтын боломж;
- Сургалт, судалгааны байгууллагуудад ойр дөт байршилтай; зэрэг болно.

Дэлхийн улс орнууд ямар паркийг түлхүү хөгжүүлэн байгуулж амжилттай ажиллуулж үр дүнд хүрсэн талаарх тодорхой туршлагыг АНУ, ХБНГУ, Хятад, Скандинав орнууд, Латви, БНСУ зэрэг улс орнуудын жишээн дээр судалж үзлээ.

АНУ-ын ШУТП-ын туршлага

Стэнфордын Их сургуулийн дэргэд 1960-аад оны эхээр анхны шинжлэх ухаан, үйлдвэрлэл, технологийн парк байгуулагдсан түүхтэй. Тус сургууль зэргэлдээх хоосон талбайгаа жижиг пүүсүүдэд түрээсэлж тэдгээр нь их сургуультай ажиллах болсноор ШУП-ийн эхлэл тавигдсан бөгөөд улмаар 1960 оны сүүл 1970 оны эхэн үеэс аж үйлдвэрийн паркийг албан ёсоор анх байгуулж эхэлсэн байна. Улмаар АНУ-д 1980 оноос ШУП олноор үүссэн бөгөөд эдгээрийн 30% буюу 160 нь АНУ-д ажиллаж байна.

Өнөөдөр АНУ-ын аж үйлдвэрийн паркийн хөгжлийг дэлхийн дахинаа сонгодог загварт тооцдог. Америкийн муж тус бүрд олон тооны аж үйлдвэрийн паркууд ажиллаж, бараг бүх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаагаа явуулсаар байна.

Эдгээр нь ихэвчлэн гадаад болон дотоодын олон арван компаниудыг нэгтгэсэн томоохон цогцолбор бүтэцтэй байх бөгөөд шинжлэх ухааны орчин үеийн судалгаа, үйлдвэрлэлийн шилдэг техник, технологид суурилдаг. Мөн тасралтгүй хөгжиж байгаа мэдээллийн технологи, өндөр технологийн орчин, бизнесийн өрсөлдөөний давуу талыг гишүүн байгууллагууддаа олгодог байна. Тухайлбал, Каммингсийн судалгааны парк нь академик судалгааны байгууллага, хувийн хэвшил, Засгийн газрын хоорондох өвөрмөц харилцаан дээр

тулгуурладаг бөгөөд 220 гаруй компани, 40 гаруй бие даасан технологийн төвүүдтэй хамтран ажилладаг.

“Alliance” парк

Паркийн хэлбэр: Өндөр технологи бүхий логистик, цахим-худалдаа, худалдааны холимог бүтэцтэй. Зорилго нь өөрийн түрээслэгчдийн бараа бүтээгдэхүүн, түүхий эд материалын урсгалыг хангах логистикийн үйлчилгээг сайжруулах явдал юм.

Паркийн байршил: Хойд Америкийн буюу Хойд Техасын Чөлөөт Худалдааны бүсэд буюу Форт Ворт хотын хойд хэсгээс 24.1 км, Далласын олон улсын нисэх онгоцны буудлын баруун хэсгээс 24.1 км, Даллас хотын баруун хэсгээс 48.2 км зайд оршдог. Тус Паркийн төв хэсэгт Форт Ворт Аллианс нисэх онгоцны буудал байрладаг.

Паркийн удирдлага: Холбооны Нисэх Хүчний Удирдах Газар (ХНХУГ), Техасын Тээврийн Газар, Форт Ворт хот болон Хиллвууд компани бүхий хувийн болон төрийн өмчийн хамтын зохион байгуулалттай.

Паркийн хөгжлийн түүх: Хиллвууд компани 1984-1994 онд 6070 га газар хамгаалалтандаа авч “Alliance” гэж нэрлэх болжээ. 1987 оны 1 сард Холбооны Нисэх Хүчний Удирдах Газрын Росс Райрот-д хандан түүний эзэмшиж байсан 1052 га газарт бүсийн нисэх онгоцны буудал байгуулах санал тавьснаар Perot төрийн байгууллагатай хамтран “Alliance” тээврийн төв байгуулахаар шийдсэн байсан. Ингээд эхний шатанд Форт Ворт хотын 182 га газарт Форт Ворт Alliance нисэх онгоцны буудал болон зарим үйлчилгээний газруудыг байгуулсан бөгөөд ХНХУГ 2926 м буух зурвасыг санхүүжүүлж, Форт Ворт хот цэвэр бохир усны систем, авто зам зэрэг бүхий л нийтийн хангамж үйлчилгээгээр хангах ажлыг хариуцжээ. Түүнчлэн замын системийг сайжруулахын тулд Хиллвууд Техасын тээврийн газар болон бусад газрын эзэдтэй хүчээ нэгтгэсэн байна. Тавьсан зорилго, зорилтууддаа хүрч хуваарийн дагуу ажлаа зохион байгуулахын тулд

долоо хоног бүр уулзалт зохион байгуулдаг байсан бөгөөд 1989 онд Форт Ворт Аллианс нисэх онгоцны буудал нээлтээ хийсэн юм.

Аллианс парк байгуулах эхний ээлжийн ажилд дэд бүтцийг хөгжүүлэхэд зориулж улсын төсвөөс 138.6 сая ам.доллар, хувийн сектор 3.7 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн байна. 1999 оны 6 сарын байдлаар улсын болон хувийн хэвшлийн нийт хөрөнгө оруулалт 3.8 тэрбум ам.долларт хүрсэн ба нийт хөрөнгө оруулалтын 96%-ийг хувийн хэвшлийн компанийн эх үүсвэрээр бүрдүүлсэн гэж мэдээлсэн байдаг.

Аллианс паркийг жирийн улаан буудайн талбайгаас олон улсын нисэх онгоцны буудалтай логистикийн сүлжээний төв болон хөгжихөд парк төлөвлөлтийн баг, эдийн засагчид, архитекторууд, хүрээлэн буй орчны зөвлөгчид, төрийн байгууллагын мэргэжилтнүүд хамтран ажилласан юм. Alliance парк 17000 байнгын, жилд 6500 хагас цагийн ажлын байрыг бий болгосноор ажлын байр бий болгох, эдийн засгийг хөгжүүлэх гэсэн хоёр үндсэн зорилтондоо хүрч чадсан юм.

Аллианс парк худалдаа, албан газар, үйлдвэрлэлийн зориулалттай 1467820 м² талбайтай ба үүний 41% буюу 603850 м²-ийг Хиллвууд компани дангаараа үлдсэн хэсгийг бусад эзэмшигчид эзэмших бөгөөд 6 дүүргээс бүрдэнэ.

- Alliance center. 1052 га талбайтай Форт Ворт нисэх онгоцны буудлыг хүрээлэн орших бизнесийн цогцолбор
- Alliance Gateway. 971 га талбайтай аж үйлдвэрийн дүүрэг ба томоохон хэмжээний үйлдвэрлэгч, борлуулагчдад үйлчлэх зориулалттай агуулах
- Westport at Alliance. 607 га талбайтай, түрээслэгчдийг төмөр зам болон бусад тээврийн хэсгүүдтэй холбохоор зохион байгуулагдсан боомт
- Alliance Commerce Center. 121.4 га талбайтай, албан газар, хуваарилалт, хөнгөн үйлдвэр болон үйлчилгээ бүхий худалдааны төв

- Alliance Advanced Technology Center. 566.5 га талбайтай, өндөр технологийн судалгааны төв
- Alliance Crossing. 68.7 га талбайтай, жижиглэн худалдаачид, ажилчид, ойр орчны оршин суугчдад үйлчлэх зориулалттай байгуулагдсан газар.

Сургамж, туршлага:

- Томоохон хэмжээний ихэнх төслүүд санхүүгийн болон зах зээлийн хүндрэлтэй асуудлуудтай тулгардагтай адил Alliance паркад ч бас асуудал үүсч байсан байна.
- Улаан буудайн талбайгаас Олон улсын нисэх онгоцны буудал болгон өөрчлөх зардлыг бууруулахын тулд төслийн ажилтнууд өөрсдөө нөөцийн менежер зэрэг зарим албан тушаалтны үүргийг давхар гүйцэтгэж байв.
- Иймэрхүү том төслийг удирдах, төсөлд бусдыг итгүүлэх, үйл ажиллагааг идэвхижүүлэхэд нэг бус эрсдэлтэй тулгарч байсан.
- Alliance-ийг амжилттай хэрэгжүүлэх эсэх нь ихээхэн аз сорьсон зүйл байсан ч аз болоход орон нутгийн байгууллага үүргээ ухамсарлан хариуцлагатай оролцсон. “Хиллвууд” төсөл хэрэгжүүлэгч төдийгүй олон нийтийн үйлчилгээ үзүүлж, эдийн засгийн хөгжлийг дэмжиж байсан нь нутгийн олон нийтийн дэмжлэгийг авах шалтгаан болсон байна.

“Иова” парк

АНУ-ын үйлдвэрлэл, технологийн “Иова” парк нь 147 гаруй корпорацитай бөгөөд түүний үйлдвэрлэл, цех тасаг, технологи, бизнесийн төвд нийт 4300 байнгын ажиллагсад ажиллаж байна. Тус парк Ховкий их сургуулийн дэмжлэгтэйгээр шинээр бизнес эхлэх болон бизнесийнхээ цар хүрээг өргөжүүлэхээр зорьж буй паркад харьяалагдах компанийн ажиллагсдад зориулан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг байна.

Иова паркад үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжид Засгийн газраас дараах хэд хэдэн санхүүгийн урамшуулал үзүүлдэг байна. Үүнд:

- Газрын урамшуулал
- Татварын урамшуулал
- Зарим зээл тусламжийн урамшуулал
- Татварын хөнгөлөлт ба чөлөөлөлт
 - Эхний жил орлогын 75%-ийн хөнгөлөлт үзүүлнэ
 - Хөрөнгийн татвараас 5 жил чөлөөлнө
 - Гадаад улсад борлуулалт хийсэн бол борлуулалтын орлогод улсын орлогын татвар төлөхгүй

Иовад борлуулсан орлогоос татвар ногдох орлогыг тооцохдоо компанийн орлогын татварт 50%-ийн чөлөөлөлт эдэлнэ.

ХБНГУ-ын ШУП-ын туршлагаас

“Regensburg” технологийн парк

Паркийн хэлбэр: Тус парк нь албан газар, бөөний болон жижиглэн худалдаа, үйлчилгээний байгууллага болон спортын цогцолборыг агуулсан бизнесийн парк юм. Анх 110000 м² талбайг түрээслүүлэхээр тооцоолсноос 10000-15000 м² талбайг нь албан газрын зориулалтаар ашиглахаар төлөвлөсөн болно. Гэвч албан газрын зориулалтаар ашиглах талбайн эрэлт маш их байсан учир илүү ихийг хуваарилсан ба энэ нь газрын үнэ цэнийг нэмэгдүүлсэн. Түрээслүүлэх нийт талбай 154000 м² үүний хагас нь албан газрын зориулалтаар ашиглагддаг. Бөөний худалдааны бизнес, спортын цогцолбор, эрүүл мэндийн байгууллагууд зах зээлийн чухал сегмент юм.

Паркийн байршил: Регенсбург нь Германы зүүн өмнөд хэсэгт орших Бавари мужийн дөрөв дэх том хот бөгөөд хурдацтай хөгжлийн бүсэд байрладаг. 1980-д оны сүүлээр Регенсбургийг дотоод зах зээл болон Европын зах зээлтэй холбосон авто замтай болсон нь тус бүс нутаг дахь аж үйлдвэрийн шинэ хөгжлийг идэвхижүүлжээ.

Паркийн эзэмшигч: Richtberg Vermögensverwaltung

Паркийн хөгжлийн түүх: 1979 онд Richtberg Vermögensverwaltung ямар ч хөгжлийн төлөвлөгөө байхгүй хуучин аж үйлдвэрийн 22 га талбайг эзэмшилдээ авсан байна. Хотын төв хэсэг галт тэрэг, төв замтай холбогдоход бэлэн байв. Тус газрыг хөгжүүлэх төлөвлөгөөг ямар нэгэн хотын захиргааны шахалт шаардлагагүйгээр боловсруулсан ба төлөвлөгөөнд Паркийн ногоон байгууламжийг хамгийн багадаа 15% байхаар тусгажээ. Учир нь Richtberg Vermögensverwaltung нь үзэсгэлэнт байгаль гэдэг бол Паркийн үнэ цэнийг өсгөх чухал хүчин зүйл гэж үзсэн бөгөөд Бизнесийн Паркийг удаан хугацаагаар үнэ цэнэтэй байлгахын тулд газрын төлөвлөлт, дизайныг онцгойлон авч үзжээ. Бүс нутгийн онцлогийг сайн мэддэг архитекторууд барилгын дизайныг гаргаж цэцэрлэгийг хадгалж үлдэхийн тулд гадаад талбайн дизайныг гаргахад орчны төлөвлөгчийг хөлслөн ажиллуулсан байна. Ингэснээр бүх барилга байгууламж өнөөгийн түрээслэгчдийн хүсэлд нийцэхээр загвар дизайнтай болж чадсан. 1981 оноос талбай түрээслүүлж эхэлсэн ба энэхүү үйл ажиллагааг Паркийн менежментийн болон лизингийн баг хариуцан ажиллаж байв.

Паркийн дэд бүтэц: Паркийн эзэмшигч нь Паркийн бүхий л авто зам, цахилгаан, усны шугам хоолой, газ, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийг бий болгосон бөгөөд эдгээрийг хувийн эзэмшилд байлгасаар байна.

Паркийн үйлчилгээ: Паркийн 3500 автомашины зогсоолыг 4500 ажилтан, өдөрт зочилдог 14300 хүнд ашигладаг. Барилгын даацад ихээхэн анхаарал хандуулдаг ба барилгын доторх цахилгаан шат нь бөөний болон жижиглэн худалдаачид, үзэсгэлэнгийн танхим, агуулах, болон үйлчилгээнд ашиглахаар төлөвлөгдсөн. Тус Паркийн хүний сонирхол татах байдлыг нэмэгдүүлэхийн тулд зарим нэгэн нэмэлт үйлчилгээнүүдийг бий болгосон. Тухайлбал хэлэлцээрийн танхим, цэвэр цэмцгэр албан тасалгаанууд, ресторан, бичиг хэргийн дэлгүүр, хуулийн болон татварын зөвлөгөө өгөх төв, зар сурталчилгааны агентлаг, зочид буудал зэрэг

байна. Жижиглэн худалдааны хэсэгт супермаркет, нарийн боовны дэлгүүр, эмийн сан, банк, эмнэлэг, үсчин зэрэг байдаг.

Сургамж, туршлага:

- Тус парк нь зах зээлийн нөхцөл байдалд нийцэн өөрчлөгдөж чадсан. Анх 10 жилийн хугацаанд ихэнхдээ хөнгөн үйлдвэрийн агуулахын зориулалттай 110000 м² талбайг байгуулах төлөвлөгөөтэй байсан бол албан тасалгааны зориулттай талбайн эрэлт хэрэгцээ их байсантай холбогдуулан нийт талбайг 154000 м² болгон өргөжүүлж, илүү том албан тасалгааны бүрэлдэхүүнд зохицуулан өөрчлөн зохион байгуулж хөгжлийн хугацаагаа 18 жил болгон сунгасан.
- Үйлдвэрлэлийн зориулалттай газрын зориулалтыг өөрчлөх нь анхнаасаа эрсдэлийг дагуулж байсан ба эвдэрч гэмтсэн газар, хуучин байшингийн суурь, бохирдол зэргийг дахин зохион байгуулахад ихээхэн хэмжээний зардал гаргасан гэдэг.

Берлин Адлерсхофын ШУТ-ын Парк (WISTA)

- Берлин-Адлерсхоф дахь шинжлэх ухаан, технологийн парк нь 1991 онд Германы Ардчилсан Бүгд Найрамдах Шинжлэх Ухааны Академийг татан буулгасны дараа байгуулагдсан юм. Өнөөдөр энэ нь 4.2 хавтгай дөрвөлжин км талбайг хамардаг бөгөөд Германы хамгийн том шинжлэх ухааны парк болжээ.
- Берлиний Адлерсхоф шинжлэх ухааны хотхон бол Германы хамгийн өндөр технологийн төвийн нэг бөгөөд Берлиний хамгийн том медиа хөгжүүлэлтийн гол цэг юм. Энэ нь 4.2 км² талбай бүхий 1,203 компани болон шинжлэх ухааны байгууллагуудын төвлөрөл болжээ.
- Байршил: Зүүн өмнөд Берлин; Берлин Бранденбург нисэх онгоцны буудал BER -тэй маш ойрхон; Нийтийн тээвэр, хурдны замтай шууд холбогддог.

- Энд 23,500 хүн ажиллаж, 6,458 хүн суралцаж байна. Adlershof Science City-ийн зүрхэн дэх Адлерсхоф шинжлэх ухаан, технологийн парк дахь компаниуд болон их дээд сургуулийн бус судалгааны байгууллагууд дараахь чиглэлээр анхаарлаа хандуулдаг.
 - Фотоник ба оптик,
 - Сэргээгдэх эрчим хүч ба фотоволт судлал,
 - Микросистем ба материал судлал,
 - Мэдээллийн технологи ба медиа,
 - Биотехнологи ба байгаль орчин.
- Түүнчлэн Берлиний Хумболдын их сургуулийн 6 шинжлэх ухааны хүрээлэн идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг (Хими, Газар зүй, Компьютерийн шинжлэх ухаан, Математик, Физик, Сэтгэл судлал).
- Ойр орчимд 189 компанитай Медиа хотхоноос гадна 454 арилжааны аж ахуйн нэгж, дэлгүүр, зочид буудал, зоогийн газрууд байгуулагдсан. 45 га талбайд Шинжлэх ухаан, технологийн парк нь цаашдын өсөлтөд хамгийн тохиромжтой орон зай болох цэцэрлэгт хүрээлэн бий.
- Адлерсхоф бол зөвхөн ажлын байр биш юм. Айлын орон сууц, түрээсийн болон өмчлөгчийн байр, таун хаус, оюутны орон сууц баригдсан. 2019 онд 4000 орчим хүн Адлерсхофын хөгжлийн бүсэд амьдарч байжээ. Орон сууцны нэмэлт барилгууд одоогоор баригдаж байна.
- 5 технологийн төвтэй ба энд нээлттэй лаборатори, семинар, оффисын түрээсийн өрөө байрладаг. Эдгээр инноваци ба бизнес инкубацийн төв нь гарааны бизнесийн үйлчилгээг санал болгодог ба хамтарсан төсөл боловсруулах, мэргэжлийн сүлжээнд хамруулах, Үндэсний болон олон улсын хамтын ажиллагааг идэвхижүүлэх,; арга хэмжээ, үзэсгэлэн худалдааг зохион байгуулдаг. Шинжлэх ухаан, судалгаа Их сургуулийн бус томоохон судалгааны байгууллагууд байрладаг:
 - Германы сансар судлалын төв,

- FBH-Фердинанд-Браун-Институт,
- Лейбницын болор өсөлтийн хүрээлэн
- Шугаман бус оптик ба богино импульсийн спектроскопийн Макс Борн институт,
- Германы Үндэсний хэмжилзүйн хүрээлэн;

БНХАУ-ын паркийн туршлагаас

1978 онд БНХАУ-ын Төрийн зөвлөл, Коммунист намаас гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих асуудлыг эдийн засгийн хөгжлийн тулгуур бодлогоо болгож, тусгай бүс, аж үйлдвэр, технологийн парк бий болгох замаар гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн нь улсын эдийн засгийг өсгөн, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд нөлөө үзүүлсэн. Чөлөөт бүс, аж үйлдвэр, технологийн парк байгуулах гол зорилго нь макро эдийн засгийн зорилтуудыг биелүүлэхийн зэрэгцээ тухайн орон нутаг, хот тосгоны дэд бүтэц, зам харилцаа барилга байгууламж, хот байгуулалтын хувьд хөгжүүлэх, хүн амын амьжиргааг дээшлүүлэх, ажлын байраар хангах, боловсрол нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэгддэг. Тус улсын туршлагаас харахад чөлөөт бүс, үйлдвэр технологийн парк байгуулан, үйл ажиллагаа явуулахад эхний таваас арван жилд төсөвт орлого оруулдаггүй өөрөөр хэлбэл тэндээс татаас авдаггүй. Эдийн засгийн хувьд бүрэн биеэ дааж хөгжсөний дараагаар улсын төсөвт орлого оруулж эхэлдэг байна.

Шанхай хотын Бошань парк

Энэ нь 1995 онд анх байгуулагдсан бөгөөд Одоогоор 150 компани үйл ажиллагаа явуулдаг. Паркийн пүүс компаниудыг үйлдвэрлэх бүтээгдэхүүнээр дараах байдлаар төрөлжүүлдэг байна. Үүнд:

- Электрон бүтээгдэхүүн;
- Нано технологиор шинэ төрлийн материал үйлдвэрлэх;

- Машин, машины сэлбэг;
- Лазер машин болон нарийн тоног төхөөрөмж;

Паркууд дараах онцлог шинжтэй байна. Үүнд:

- Паркийн байршлыг авто зам, нисэх онгоцны буудал, гаальтай ойролцоо сонгож бүх төрлийн үйлчилгээг нэг дор төвлөрүүлсэн ба удирдах байгууллага, ажилтнуудын орон сууц, эмнэлэг, цэцэрлэг, дунд сургууль, их, дээд сургууль, цагдаа, гал команд бүгд байршсан.
- Цахилгаан, цэвэр ба бохир ус, шатах хийгээр найдвартай хангагдсан.
- Паркад хөрөнгө оруулалт хийсэн дотоод гадаадын компаниуд оруулсан хөрөнгийн хэмжээнээс хамааруулж 1 га газрыг худалдах үнэ ялгаатай, татварын хөнгөлөлт, урамшуулалт эдлэх ба экспортийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, оюуны үйл ажиллагаа явуулах нөхцөлд урт хугацаагаар татвараас чөлөөлөгдөнө.
- Уг паркад хөрөнгө оруулалт хийхэд зуучилсан хүнийг хүртэл бодит орлогын 1% хүртэлх урамшуулал олгодог байна.
- Хятадын төрөөс 50 сая юанийн хөрөнгө оруулалт хийсэн.
- Эрдэм шинжилгээний байгууллага, үзэсгэлэн яармагийг үйлдвэрийн ойролцоо байрлуулсан нь нягт уялдаатай хамтран ажиллах боломжийг бүрдүүлсэн байна.
- Гадаадын хөрөнгө оруулалтыг татвараар урамшуулдаг.

Шанхай хотын Технологийн парк

Паркийн дэд бүтэц. Шанхайн зүүн хэсэгт байрладаг уг хотхоны дэд бүтэц нь:

- Усан хангамж. Хотхоныг өдөрт 300000 тонн усаар хангах хүчин чадалтай 2 станцтай.
- Эрчим хүч хангамж. Эрчим хүчний гурван газраас 35 кВт эрчим хүч нийлүүлдэг ба өдөрт 120 сая ваттаар хангах хүчин чадалтай.

- Хийн хангамж. Үйлдвэрлэлийн паркад хамгийн сайн хий хэрэглэгддэг. Уг хийг Хятадын баруун мужуудаас өдөрт 300.000 м³ хэмжээгээр нийлүүлдэг ба баруун мужуудын хий нь Сианжины Тарим Басины байгалийн хийн нөөцөөс ихээхэн хамаарна. Баруунаас зүүн хязгаар луу байгалийн хийн тээвэрлэлт төслөөр 4200 км тээвэрлэлтийн шугам баригдсан ба энэхүү шугам нь Таримын Басинаас Шанхай руу Гансу, Нинхай, Шанси, Синан, Жанху зэрэг мужуудаар дайрсан байдаг.
- Цахилгаан холбоо. Хотхонд 100000 орчим программаар хянагдсан эрчим хүч, телефон солилцоо чөлөөтэй ба ISDN, IDD, DDD, ASDL, FTTB болон бусад төрлийн сайжруулсан цахилгаан холбоогоор хоорондоо холбогддог.
- Бохир усны суваг. Өдөрт 100000 тонн усыг цэвэршүүлэх чадвартай станцтай.
- Борооны усан суваг. Уг сувгийн хоолойн диаметр нь 450-2000 мм ба 2 секунд тутамд 3 м³ урсгах чадвартай.
- Авто зам. 6 чиглэлийн 36 км урт гол замтай.
- Үерийн хамгаалалт. Хотхон нь Вусоны тэг градуст 4.2-4.8 м өндөрт оршдог учир үерт автахгүй.

Үйлчилгээ. Санхүүгийн, хүний нөөцийн, гэр орон, ахуй хэрэглээний, нөөц, түүний хуваарилалтын менежментийн үйлчилгээ үзүүлэх боломжтой. Паркийн хяналт шалгалтын хэлтэс нь шинээр нээгдэж буй үйлдвэрийн газруудад цаг тухайд нь үйлчилгээ үзүүлнэ.

Ажиллах хүчний нөөц:

- Удирдлага. өндөр мэргэжил, дадлага туршлага, чадвартай хотын хүмүүс
- Ажилчид. Пиншиан хорооллын үйлдвэрийн ажилчид голлох ба ажилчдын хөдөлмөр аюулгүй байдлыг хянадаг
- Төрөл бүрийн их сургуулиуд, техникийн дунд сургууль, ерөнхий боловсролын сургууль төгссөн оюутнууд

- Тэтгэвэрт гарсан 8000 орчим ажилгүй, гэрээр ажил эрхэлдэг, ажлаасаа халагдсан болон ажилгүй болсон хүмүүс

Үйлдвэрийн паркийн хөрөнгө оруулалт. Хөрөнгө оруулалт хийх шаардлага:

- Зураг төслийн сонголт.
- Гэрээнд гарын үсэг зурах.
- Төслөө батлуулаад бүртгүүлнэ.
- Төслөө шалгуулаад зөвшөөрөл авна.
- Үйлдвэрийн барилга байгууламж

Татварын хөнгөлөлт:

- Шинээр нээгдэж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрийн татварыг эхний 2 жил чөлөөлж дараагийн 3 жил 50хувийн хөнгөлөлт үзүүлдэг
- Экспортын үйлдвэрийн хувьд жилийн экспорт нь борлуулалтын орлогын 70 хувь байвал орлогын татварыг төлөх ёстой хэмжээнээс 2 дахин бууруулж тооцно
- Засгийн газраас дэмжигдсэн өндөр технологийн үйлдвэрийн төсөл болон тоног төхөөрөмж нь экспортын татвараас чөлөөлөгдөх ба импортын тарифаас тоног төхөөрөмж нь чөлөөлөгдөнө

Циндаогийн шинжлэх ухааны парк

Циндаогийн ШУП нь 1992 онд 67 км² талбайд байгуулагдсан ба Хятадын зүүн талд байрладаг. Уг парк нь дараах хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Үндэсний шинэ/өндөр технологийн бүс
- Шилаорены үндэсний аялал жуулчлалын түшиц газар

Үйлдвэр нь тээвэр, харилцаа холбооны системээр хангагддаг бөгөөд байгалийн үзэсгэлэнт сайхан газартай, шаардлагатай тоног төхөөрөмжтэй, сүүлийн үеийн аж үйлдвэрийн өндөр технологитой.

Циндаогийн ИТХ, Удирдах хороо нь дотоод гадаадын хөрөнгө оруулагчдад чанарын өндөр түвшинд үйлчилгээ үзүүлэхийг хариуцдаг ба банк, НББ-н байгууллага, Аудитын байгууллага, Даатгалын компаниуд, Гадаадын хөрөнгө оруулагчдын үйлчилгээний төв, Гадаадын үйлдвэрийн нийгэмлэг зэрэг байгууллагатай хамтран ажилладаг.

Циндаогийн паркийн дэд бүтцийг бий болгоход нийт 2.4 тэрбум юанийн хөрөнгө оруулалт хийсний дотор Коко кола, Лусент, НР гэх мэт 30 орчим алдартай компаниуд хөрөнгө оруулалтанд оролцсон байна.

Паркийн нийт экспорт нь 240 сая доллар ба нийт ДНБ нь 8.6 тэрбум юань байна. Сүүлийн үеийн статистик мэдээгээр 638 гадаадын болон хамтарсан үйлдвэрүүд нийт 2.4 тэрбум долларын хөрөнгө оруулалт хийснээс 62 орчим нь 10 саяаас дээш хөрөнгө оруулалтыг хийжээ.

Татварын хөнгөлөлт:

- Шинээр бий болж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрийн татварыг эхний 2 жил чөлөөлөөд дараагийн 3 жилд 50%-иар хөнгөлдөг.
- Экспортын үйлдвэрийн хувьд жилийн экспорт нь борлуулалтын орлогын 70% байвал орлогын татварыг төлөх ёстой хэмжээнээс 2 дахин бууруулж тооцно.
- Үйлдвэр, аж ахуй нэгжийн орлогын албан татварт 15%-ийн татвар ногдуулдаг ба орон нутгийн орлогын албан татвараас чөлөөлдөг.
- Далайн боомт, онгоцны зогсоол, эрчим хүч, замын хөдөлгөөний төсөлтэй, тэр төсөл нь 15-аас дээш хугацаатай гадаадын хөрөнгө оруулалттай аж үйлдвэрүүдийг 5 жил аж ахуй нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөөд дараагийн 5 жилд 50%-иар хөнгөлнө.
- Засгийн газраас дэмжигдсэн өндөр технологийн үйлдвэрийн төсөл болон тоног төхөөрөмж нь экспортын татвараас чөлөөлөгдөх ба импортын тарифаас тоног төхөөрөмж нь чөлөөлөгдөнө.

Шэнжэний инновац, технологийн парк

Тус парк нь 1996 онд байгуулагдсан ба 11.5 км кв талбайтай. Нийт аж үйлдвэрийн гарц нь 89.5 тэрбум юань бөгөөд Шэнжэний нийт бүтээгдэхүүний 18%-ийг эзэлдэг. Шэнжэний эдийн засгийн онцгой бүс нь үйлдвэр технологийн паркад үр ашигтай нөлөө үзүүлж байгаа бөгөөд хөгжлийг бий болгож чадсан байна.

Шэнжэний нийт ДНБ нь 223.941 тэрбум, нийт экспорт импортын хэмжээ 87.1 тэрбум, үүнээс экспорт 46.52 тэрбум юанийг эзлэж байна. Нийт аж үйлдвэрийн бүтээгдэхүүн 422.1 тэрбум юаньд хүрчээ. ШУП-ын бүтээгдэхүүн нийт аж үйлдвэрийн бүтээгдэхүүнд 46%-ийг эзэлж байна.

Шэнжэний паркад компьютер болон түүний эд анги, харилцаа холбооны тоног төхөөрөмж, аудио визуал бүтээгдэхүүн, харааны болон электро механик бүтээгдэхүүн, биологи инженерийн бүтээгдэхүүнүүд зэргийг үйлдвэрлэдэг.

1) Татварын бодлого

Орлогын татвар:

- Орлогын татварыг нь улсын болон орон нутгийн гэж ангилдаг. Улсын татвар нь 30 хувь, орон нутгийн татвар нь 3% байдаг
- Аж ахуй нэгжийн орлогын албан татварт 15%-ийн татвар ногдуулдаг ба орон нутгийн орлогын албан татвараас чөлөөлдөг
- Далайн боомт, онгоцны зогсоол, эрчим хүч, замын хөдөлгөөний чиглэлээр хийгдсэн 15-аас дээш жилийн хугацаатай үргэлжлэх төсөл бүхий гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийг 5 жилийн хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөөд дараагийн 5 жилд 50%-иар хөнгөлнө
- Гадаадын хөрөнгө оруулалттай боловсруулах үйлдвэрүүдийг 2 жил татвараас чөлөөлөөд дараагийн 3 жил 50%-ийн хөнгөлөлт олгоно

- Үйлдвэрүүдийн экспортын хэмжээ нь нийт бүтээгдэхүүний 70 хувиас илүү гарсан тохиолдолд аж ахуй нэгжийн орлогын албан татварыг бууруулж 10%-иар ногдуулдаг. Харин боловсруулах үйлдвэрүүд нь улсын технологийг ашигласан бол татварыг бууруулж 3 жил 10%-иар ногдуулдаг
- Гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрүүдийн хөрөнгө оруулалтын хэмжээ 5 сая доллараас илүү, 10 жилийн хугацаатай бол эхний жил аж ахуй нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөөд дараагийн 2 жил 50% хөнгөлнө
- Гадаадын хөрөнгө оруулалттай, өндөр технологитой үйлдвэрүүдийг 2 жил аж ахуй нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөөд дараагийн 6 жил 50%-ийн хөнгөлөлт үзүүлнэ
- Өндөр технологийн бие даасан төслийг аж ахуй нэгжийн орлогын албан татвараас 5 жил чөлөөлөөд дараагийн 3 жил 50%-ийн хөнгөлөлт үзүүлнэ
- Программ хангамжийн үйлдвэрүүдийг эхний 2 жил ашгийн татвараас чөлөөлөөд дараагийн 3 жил 50%-ийн хөнгөлөлт үзүүлнэ

НӨАТ. Уг татварын хувь хэмжээ нь 17% байдаг. Гэхдээ зарим бараа үйлчилгээнд 13%-иар тогтоодог. Гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрүүд дараахь хөнгөлөлтүүдийг эдэлнэ.

- Бие даасан оюуны өмчийн эрхтэй өндөр технологийн төсөл бүхий үйлдвэрийн орон нутагт төлөх НӨАТ-ын хэмжээг 50% хөнгөлнө
- Шинэ бүтээгдэхүүн, шинэ бүтээл бий болгосон болон 2-3 жил турш Шэнжэнд үйлдвэрлэсэн бол тухайн үйлдвэрийн орон нутагт төлөх НӨАТ-аас 50% хөнгөлнө

Бизнесийн татвар. Бизнесийн татвар нь дунджаар 3-20% байдаг. Гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрүүдэд дараах хөнгөлөлт үзүүлнэ. Үүнд:

- 10 жилийн хугацаатай 100 сая юанийн хөрөнгө оруулалт хийсэн бол үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс нь хойш 5 жил бизнесийн татвараас чөлөөлнө
- Бие даасан өмчийн эрхтэй өндөр технологийн төсөл бүхий үйлдвэрүүдийг эхний 5 жил татвараас чөлөөлөөд дараагийн 3 жил 50 хувийн хөнгөлөлт үзүүлнэ

Хүн амын орлогын албан татвар. Хүн амын орлогын албан татвар нь 9 шатлалтай ба 5-45% байдаг бөгөөд үйлдвэрийн ажилчид нь үйлдвэр болон төслийн шагнал, ногдол ашгаасаа үйлдвэрийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийсэн бол хүн амын орлогын албан татвараас чөлөөлнө. Хэрвээ ногдол ашгаа төлсөн эсвэл шилжүүлсэн бол ашгийн хэмжээнд татвар ногдуулна.

- 2) **Санхүүгийн тэтгэмж.** Үйлдвэрийн үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн чиглэлийн шилжүүлэг, банкны үйлчилгээнд хөнгөлөлт үзүүлдэг.
- 3) **Газрын бодлого.** Өндөр технологи оруулж үйл ажиллагаандаа хэрэглэдэг бол тухайн үйлдвэр газрын ашиглалтын төлбөрөөс 50%-ийн хөнгөлөлт эдэлнэ.

Тайваны шинжлэх ухааны парк

Үйлдвэрийн зориулалттай газрын асуудлыг шийдвэрлэх, үйлдвэрийн төвлөрлийг эдийн засгийн үр ашигтай болгох, үйлдвэрийн ойр орчмын байгаль сүйдэхээс сэрэмжлэх, орон нутгийн эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, байгальд ээлтэй өндөр өртөгтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэл бий болгох, засгийн газраас байгуулсан үйлдвэрүүдэд газар түрээслүүлэх зорилгоор Тайвань улсад анх шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн парк байгуулж эхэлсэн байна.

Хүснэгт 2. Тайваны паркад нэгдэх компанид тавих шаардлага

Тавигдах шаардлага	Шаардагдах хөрөнгийн хэмжээ	Үйлдвэр, технологийн паркийн чиглэл	Урамшуулал
1. Технологи, үйлдвэрлэлийн хөгжил сайн байх	Компани байгуулахад байх ёстой хөрөнгийн хамгийн доод хэмжээ компаний дүрмийн дагуу 1 сая Тайвань доллар байх.	1. Интегралчлагдсан микро схем үйлдвэрлэгчид	1. Татварын урамшуулал
2. Хөрөнгө оруулалт нь Тайваны үйлдвэр, технологийн хөгжилтэй нийцсэн байх ба шинжлэх ухааны болон техникийн сургалттай байх.		2. Компьютер болон түүнтэй холбогддог тоног төхөөрөмж үйлдвэрлэгчид	2. Хөрөнгө оруулалтад засгийн газар оролцож дэмжлэг үзүүлэх
		3. Холбоо	3. Технологийн солилцоо явуулах нөхцлөөр хангах
		4. Эрчим хүчний төхөөрөмж үйлдвэрлэгчид	4. Зээлийн бага хүү санал болгох
		5. Нарийн мэргэжлийн үйлдвэрийн машин төхөөрөмж үйлдвэрлэгчид	5. Судалгаа болон хөгжлийн урамшуулал олгох
3. Үйл ажиллагаанаас олох ашиг нь судалгаа шинжилгээ, хөгжилд зарцуулагддаг байх.			

4. Судалгааны хэрэгсэл болон тоног төхөөрөмж нь аливаа бохирдол бий болгодоггүй гэдэг нь батлагдсан байх.		6. Биотехнологийн үйлдвэрлэл	6. Өсөн дээшилж байгаа үйлдвэр, технологиудтай холбоотой хууль дүрэм батлах
---	--	------------------------------	---

Тайвань дахь паркийн түрээсийн төлбөрийг депозит болон бонд хэлбэрээр хийх боломжтой.

Урамшуулал. Паркийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Тайваний Засгийн газраас дараах урамшууллын олон хэлбэрийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Газар болон барилгын талбай
 - Засгийн газрын хөгжлийн сангаас 200 сая ам. доллар түүнээс дээш хувийн хөрөнгө оруулалтын төсөлд дунд болон урт хугацааны хөнгөлөлттэй санхүүжилт хийнэ. Мөн төрийн бодлоготой холбоотой төслүүдийг батлан даана.
 - Эдийн засгийн хөгжил болон төлөвлөлтийн зөвлөлөөс үйлдвэрийн зориулалтаар газар, барилга түрээслэх, худалдан авахад 60 тэрбум ам. долларыг урт ба дунд хугацаагаар зориулахаас гадна үйлдвэрийн газар, барилгын зардлыг бууруулж, санхүүгийн дарамтаас хөнгөлдөг.
 - Үйлдвэрийн газрын ашиглалтын дүрэмд зааснаар газрыг бүрэн болон хэсэгчлэн зарах, бусад үйлдвэрүүдэд үйлдвэрийг газрыг давхар түрээслэх эрх олгодог.

- Машин, тоног төхөөрөмж
 - Агаар болон ус бохирдуулахаас сэргийлдэг, чимээ намсгагчтай, дохиололтой тоног төхөөрөмжийг импортлоход татвараас чөлөөлнө.
 - Нөөцийг дахин цэвэрлэдэг болон бохирдлын хяналттай, үйлдвэрийн усыг дахин цэвэрлэдэг, газрын элэгдэлд нөлөөлдөг хийг багасгадаг, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлдэг, интернет болон телевизийн үйл ажиллагаанд зориулсан техник ба программ хангамж, шуудан харилцааны болон автомат тоног төхөөрөмж, технологид ашгаасаа хөрөнгө оруулалт хийсэн бол аж ахуй нэгжийн орлогын татвараас хасаж тооцно. Зарим тохиолдолд санхүүгийн хөнгөлөлт үзүүлэх нь ч бий.
 - Судалгаа шинжилгээ, хөгжил дэвшил, туршилтын зориулалтаар эрчим хүч хуримтлуулдаг, шалгалтын чанартай, шинэ болон цэвэр түлш хэрэглэдэг тоног төхөөрөмжийн элэгдлийг 2 жилээр түргэвчлэн тооцно.
- Эрхийн бичиг болон зөвшөөрөл
 - Бүртгэл мэдээлэл, хотын бүс, барилга байгууламжийн менежментэд нийцүүлэн ашгийн төлөө үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын шатах хөдөлгүүрийн төхөөрөмжтэй эсэх, хаяг дугаартай, газрын үзлэгт орох эсэх, байгаль орчны хамгаалалт болон ажилчдын аюулгүй байдал хэр хангагдсан зэргийг хянах нэгдсэн үйлчилгээтэй байдаг.
 - Үйлдвэр нь байгаль орчныг хамгаалах албаар шалгагдсан байх ёстой бөгөөд бохирдлын хэмжээ зөвшөөрөгдсөн хэмжээнээс их байвал зөвшөөрөл олгоно.

- Татварын урамшуулал

Орлогын татвар

- Зөвхөн дотоодын компаниудад 5 жилийн татвараас хөнгөлөлт эдлүүлнэ (шинэ хөрөнгө оруулах, үйлдвэрлэлийнхээ хүрээг тэлэх болон 2002 оны 1-р сарын 2-ноос 2003 оны 12-р сарын 31-ны хооронд үйл ажиллагаа эрхэлсэн бол ашгийн татвараас чөлөөлнө).
- 5 жил татвараас эсвэл хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө оруулалтанд татварын хөнгөлөлт эдлүүлнэ.
- Бизнесийн татварын хамгийн дээд хэмжээ 25 хувь байна.
- Экспортод “0” %-ийн татвар ногдуулна.

Импортын татвар

- Бондын санхүүжилттэй үйлдвэрүүдийн хувьд бүтээгдэхүүн боловсруулахад зориулж түүхий эд, материал татвараас чөлөөлөгдөнө.
- Шинжлэх ухаан, судалгааны чиглэлийн үйлдвэрүүдэд зориулсан машин, тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлнө.
- Сангийн яамнаас татваргүй гэж баталснаас бусад түүхий эд, материалыг паркийн үйлдвэрүүд импортоор авах болон бүтээгдэхүүн экспортод гаргахдаа татвар төлсөн бол тухайн өдрөөс хойш 18 сарын дотор төлсөн татварыг буцаан олгоно.

Газрын татвар

- Үйлдвэр нь үйлдвэрийн газар байх ёсгүй бүсэд харьяалагдах эсвэл олон нийтийн аюулгүй байдал, байгаль орчны бохирдолтой холбогдуулан үйлдвэрийнхээ газрыг зарах, шилжүүлэх

шаардлагатай болбол газрын татварыг боломжит хамгийн бага хувь хэмжээгээр ногдуулна.

Латви улс - Даугавпилс технологийн парк

Даугавпилс технологийн парк нь ОХУ, Беларусь, Литвийн хилийн ойролцоо оршдог Латвийн хоёрдахь том хот бөгөөд газарзүйн байршлын хувьд олон давуу талтай, дэд бүтэц сайн хөгжсөн, мэргэжлийн болон мэргэжлийн бус ажиллах хүчний нөөц ихтэй, хэд хэдэн их дээд сургуультай давуу талтай.

Латви улс нь үйлдвэрлэлийг дэмжиж, хамтын ажиллагааны таатай нөхцөл бүрдүүлэх зорилгоор Даугавпилсийн технологийн парк байгуулсан ба химийн заводын хуучин талбайг сонгон авсан байдаг. Одоогийн байдлаар паркад 19 компани ажиллаж байгаа бөгөөд хөрөнгө оруулагчид үйлдвэрлэлийн болон туслах байр, талбай, газрыг эзэмших боломжтой.

Дэд бүтэц: Усан хангамж, хий дамжуулах шугам, эрчим хүчний сүлжээтэй.

Талбай: 200 мянган квадрат метр үйлдвэрлэлийн талбайтай.

Үнэ: Түрээсийн төлбөр - 1-2,5 лат/м², худалдан авах үнэ – 50 доллар/м² орчим бөгөөд нийтийн аж ахуйн үйлчилгээ, эрчим хүчний төлбөр нэмж төлнө.

Рига аж үйлдвэрийн парк

“Рига” аж үйлдвэрийн парк нь дэд бүтэц сайтай, агуулах, албан контор, үйлдвэрийн объектуудыг санал болгодог 200000 м² талбай бүхий орчин үеийн үйлдвэрийн шинэ цогцолбор бөгөөд хөрөнгө оруулагчдад зориулан барилга байгууламжийг урт хугацаагаар түрээсэлж ашиглуулах зорилгоор Балтын тэнгисийн орнуудад 1998 онд байгуулагдсан хамгийн анхны албан ёсны парк юм. Парк нь Рига хотын төвөөс хойш 8 км, төв болон тойрог зам Via Baltica-тай ойр оршино.

Дэд бүтэц: Парк нь зам, холбоо, цахилгаан эрчим хүч, дулаан, цэвэр болон бохир усны шугам хоолойтой. Интернетийн сүлжээ, шилэн кабель бүхий барилга байгууламжтай. Паркийн гадна талд хамгаалалтын хашаатай, шөнийн гэрэлтүүлэгч, хамгаалалтын камертай.

Бусад үйлчилгээ: Аюулгүй байдлыг хангах, газар ашиглалтыг зохицуулах, хаягдал тээвэрлэх, агааржуулах, зэрэг техникийн нэмэлт үйлчилгээ үзүүлэх боломжтой.

Талбай: Агуулахын зориулалттай талбай 450-2500 м², албан тасалгааны зориулалттай талбай 370-1000 м² хэмжээг эзэлнэ.

Үнэ: Түрээсийн үнэ нь Паркийн доторхи байрлалаас хамаарах ба 1 м² нь 6.5 – 9.6 евро байна. Түрээсийн төлбөр дээр НӨАТ нэмж төлнө.

Дээрх улс орнуудын аж үйлдвэрийн Паркийн талаарх туршлагаас харахад үйлдвэрлэл технологийн парк нь мэдээлэл, мэдлэгийн эрчимтэй шинэчлэгдэх, өөрөө өөрийгөө тэтгэх эх сурвалжид тулгуурлан, аль болох их өртөг шингээсэн үйлчилгээг үзүүлэх, мөн үл хөдлөх хөрөнгө, түүхий эд материал, ажиллах хүчин, дэд бүтцийн орчин, нийгмийн хангамжийн үйлчилгээ зэрэг давуу талд тулгуурлан, материаллаг нөхцөлөөрөө эрчимтэй хөгжих боломжтой жижиг дунд үйлдвэрүүдийг өөртөө татаж, сүлжээ бий болон бүс нутгийн хөгжилд нөлөөллөө үзүүлдэг байна.

Финланд улс - Турку шинжлэх ухааны парк

- Турку шинжлэх ухааны парк бол Финляндын Турку хотын бизнес, боловсролын байгууллагуудын нэгдэл юм. Энэ нь Финляндын баруун өмнөд хэсэгт биотехнологи, мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэхэд чиглэгддэг.
- Түүний гишүүнчлэлд Турку хотод ажилладаг 300 орчим компани багтдаг. Тухайлбал Нокиа Фуцизу компани, Турку их сургууль гол 2 институци ба Турку хэрэглээний шинжлэх ухааны их сургуультай нягт хамтран ажилладаг.

- Шинжлэх ухааны парк нь Турку хотын төвийн зүүн талд, Купиттаа дүүрэгт байрладаг. Төслийн бас нэг чухал түнш болох их сургуулиуд болон TYKS төв эмнэлэг байрладаг. Шинжлэх ухааны паркийн байр нь арван нэгэн барилгад нийтдээ 210,000 м² талбайтай бөгөөд тухайн бүс нутагт байгаа төслүүдийг хангахын тулд одоогоор Купиттаад хүнд барилгын ажил хийгдэж байна. Энэхүү төслийг Турку хот нь хамгийн том хувьцаа эзэмшигчээр нь хариуцдаг хязгаарлагдмал хариуцлагатай компани болох Turku Science Park Ltd хэлбэрээр зохион байгуулж байна.

БНСУ-ын ШУП-ийн туршлагаас

Даедок Иннополис

- Даедок Иннополис, өмнө нь Даедок ШУ-ны хотхон нэртэй байсан нь Өмнөд Солонгосын Дэжон хотод байрлах судалгаа, хөгжлийн дүүрэг юм. БНСУ-ын Эдийн засгийн мэдлэгийн яамны онцгой дэмжлэгтэй ажилладаг.
- Даедок Иннополис нь 1973 онд Ерөнхийлөгч Пак Чунхигийн KAIST -ийг нээснээр байгуулагдсан судалгааны кластераас үүсэлтэй байв. Энэхүү шинжлэх ухааны кластерийг 20 гаруй томоохон судалгааны хүрээлэн, 40 гаруй аж ахуйн нэгжийн судалгааны төв бүрдүүлдэг. Сүүлийн хэдэн жилийн хугацаанд хэрэглээний шинжлэх ухааны докторын зэрэг өндөр төвлөрсөн энэ бүс нутагт мэдээллийн технологийн хэд хэдэн компаниуд бий болсон. Дэжедок мужид 232 судалгаа, боловсролын байгууллага байдаг бөгөөд тэдний олонх нь Даэдок мужид байдаг, үүнд Цахилгаан, харилцаа холбооны судалгааны хүрээлэн, Солонгосын сансар судлалын хүрээлэн байдаг. [1] "Хотхон" нь Олон улсын шинжлэх ухаан, бизнесийн бүсийг бий болгох зорилготой.
- Одоогоор 60 гаруй мянган хүн ажилладаг. 9055 доктор хамгаалсан ба энэ нь БНСУ-ын 11% орчим болно.
- Түрээслэгчид • 129 байгууллага (R&D -тэй холбоотой) байгаа ба 30 Засгийн газрын судалгааны хүрээлэн, 42 Хувийн судалгааны хүрээлэн: 8 Дэмжих

агентлагууд (олон нийтийн): бүсийн 5 их дээд сургуулиуд, 22 ашгийн бус байгууллагууд • Өндөр технологийн 1,179 компани (ЖДҮ) : GRI ба PRI-ийн хуваагдал, өндөр технологид суурилсан венчур бизнесүүд үйл ажиллагаа явуулж байна.

- Гол талбарууд шинжлэх ухааны болон Технологи IT (40%), BT (14%), Материалын шинжлэх ухаан (9%), Химийн инженерчлэл (8%), Эрчим хүчний нөөц (8%) болно.
- Хэмжээ: Нийт талбай: 70.4 км². Бүс 1-д 27.8км² - судалгаа, хөгжүүлэлтийн зориулалттай бөгөөд ажилтнуудын орон сууцны хороолол орно. Бүс 2.-д Даедок техно хөндий орох ба ба 4.3км² талбай эзэлнэ Энд венч бизнесийн бүс, туршилтын үйлдвэрүүд ордог. Бүс 3.-д Даедок аж үйлдвэрийн цогцолбор орох ба 3.1км² талбайд орон нутгийн аж үйлдвэрийн парк ба үйлдвэрлэлийн талбай ордог. Бүс 4.-д Төлөвлөсөн талбай (Ногоон бүс): 30.2км² - ногоон бүсийн бүс бөгөөд ирээдүйн төлөвлөлтийн зориулалттай газар нутгийг багтаасан болно. Бүс 5. Батлан хамгаалах хөгжлийн агентлаг: 5.0км² талбайд цэрэг, батлан хамгаалахтай холбоотой үйлдвэрлэлийн зориулалттай бүс ордог.

Улсан дахь үйлдвэрийн парк

- БНСУ-ын Сөүл нийслэлээс 389.5 км зайд орших Улсан хотод 1960-аад онд газар тариалан эрхлэгч, загасчдаас бүрдсэн 85000 гаруй амьдардаг байсан байна. 1962 онд тус хотод хүнд үйлдвэрлэлийн бүс байгуулахаар төлөвлөсөн нь эдийн засгийн хөгжлийг хурдасгахаас гадна Улсан хотын хүн амын төвлөрлийг нэмэгдүүлэх давхар зорилготой байжээ. Нефть-химийн үйлдвэр, усан онгоцны үйлдвэр, авто машины болон өнгөт төмөрлөгийн үйлдвэр олноор байгуулж амжилттай ажиллаж эхэлсэн ч хүрээлэн буй орчиндоо анхаарал хандуулалгүй орхисноос орчны хэт бохирдол нэмэгдэж, ард иргэд шилжин нүүж эхэлжээ.

- Тус улсын болон олон улсын байгууллагууд Улсан хотыг бохирдол ихтэй хотоор нэрлэх болсноор хүн амын төвлөрөл нэмэгдүүлэх зорилго биелэх боломжгүй болсон байна. Энэ үед тус улсын засгийн газар үйлдвэрлэлийн бүсийг үндэсний үйлдвэрүүдийн комплекс буюу парк болгон өөрчилж агаарын бохирдолгүй муж болгох зорилгоор дүрэм журамд өөрчлөлт оруулан компаниудыг байгаль орчны бохирдлыг бууруулах, бохирдлоос сэргийлэхэд хөрөнгө оруулахыг шаардах болсон байна.
- Эдгээр Улсан хот нь БНСУ-ын аж үйлдвэрийн хамгийн том хот бөгөөд хоёр үйлдвэрийн парк, хөдөө аж ахуйн үйлдвэрийн дөрвөн комплекс, бүсийн үйлдвэрийн таван комплексд 1000 гаруй компани, 100000 гаруй хүн ажиллаж амьдарч байгаа аж.

Словений Любляна паркийн туршлагаас

- Любляна парк нь 1995 инновацийн болон бизнесийн таатай орчинг бүрдүүлж өндөр технологийн компаниудад дэмжлэг үзүүлэх зорилгоор онд байгуулагджээ. 2012 оны байдлаар тус паркад мэдээллийн технологи, биотехнологи, вакуум технологийн чиглэлээр 295 тенант компани ажиллаж байгаагаас 131 нь өөрсдийн инкубаторт бойжсон байна.
- Любляна парк нь компаниудыг бизнес хөгжлийн хөтөлбөрөөр дэмждэг ба их сургууль, технологийн паркийн удирдлага, Словенийн технологийн агентлаг, гадаадын хөрөнгө оруулалтын агентлаг зэрэг бүс нутгийн болон үндэсний голлох стратегийн түнштэй хамтран ажиллах бүх боломж нөхцөлөөр хангаж өгдөг давуу талтай болно.

Израиль улс – Силикон Вади

- Нэр томъёоны гарал үүсэл Silicon Wadi бол АНУ-ын Калифорни мужийн Цахиурын хөндийд үндэслэсэн. "Вади" гэдэг нь араб хэлээр хөндий эсвэл хуурай голын эхийг хэлдэг бөгөөд еврей хэлээр бас түгээмэл хэрэглэгддэг.

- Израилийн өндөр технологийн фирмүүд анх 1960-аад оноос үүсч эхэлсэн. Моторола нь 1964 онд Израильд R&D нэгж байгуулсан АНУ -ын анхны корпораци юм. Энэ төв нь эхлээд алсын усалгааны системийг багтаасан утасгүй бүтээгдэхүүн боловсруулж, дараа нь тэргүүлэх чипүүдийг боловсруулсан. Эхэндээ технологи хөгжүүлэлт батлан хамгаалах салбарын C&X дээр суурилсан байв.
- Өндөр технологийн фирмүүд энэ хугацаанд маркетинг хийж, бүтээгдэхүүнээ амжилттай арилжаалж чадаагүй Дэлхийн програм хангамжийн зах зээл хөгжсөнөөр олон улсын тооцоолох салбар аажмаар техник хангамжаас (Израиль харьцангуй давуу талгүй) програм хангамжийн бүтээгдэхүүн рүү (хүний капитал илүү их үүрэг гүйцэтгэдэг) анхаарлаа хандуулсан. 1980-1990-ээд оны эхээр Израилаас хэд хэдэн амжилттай програм хангамжийн компаниуд гарч ирэв: 1990-ээд онд Израильд өндөр технологийн салбарууд жинхэнэ утгаараа хөгжив, Өсөлт нэмэгдэж, харин ЗХУ-аас шинээр ирсэн цагаачид өндөр технологийн боломжтой ажиллах хүчийг нэмэгдүүлэв. 1993 оны Осло хотын Энх тайвны гэрээ зэрэг энхийн гэрээ нь хөрөнгө оруулалтын орчныг нэмэгдүүлж, Цахиур Вади нь өндөр технологийн мэдэгдэхүйц кластер болж хөгжиж эхлэв.
- Силикон Вади өнөөдөр 50 гаруй жилийн турш тус улсын хүн ам хурдацтай өсч, амьжиргааны түвшин дээшилсэн тул орон нутгийн эрэлт нь Израилийн аж үйлдвэрийн тэлэлтийг дэмжсэн юм. Саяхан Израилийн дэвшилтэт технологи, програм хангамж, электроник болон бусад нарийн тоног төхөөрөмжийн дэлхийн эрэлт хэрэгцээ аж үйлдвэрийн өсөлтийг өдөөж байна. Израиль шинэ технологид өндөр байр суурь эзэлж байгаа нь дээд боловсрол, судалгаа, боловсролд онцгой анхаарал хандуулж байгаагийн үр дүн юм.
- Силикон Вади өргөтгөн хөгжилд нөлөөлж буй соёлын хүчин зүйлс нь цагаачлал, оюуныг татах, нээлттэй байх явдал юм. Засгийн газар мөн хөгжлийн төсвөөсөө бага хүүтэй зээл олгох замаар аж үйлдвэрийн өсөлтөд

тусалдаг. Аж үйлдвэрийн хувьд тулгарч буй гол хязгаарлалт бол дотоодын түүхий эд, эрчим хүчний эх үүсвэрийн хомсдол, дотоодын зах зээлийн хязгаарлагдмал хэмжээ юм. Тодорхой нэг давуу тал бол Израилийн их дээд сургуулиудыг төгссөн олон хүмүүс мэдээллийн технологийн бизнес эрхлэгч болох эсвэл гарааны бизнес эрхлэх магадлалтай байдаг нь АНУ -ын их дээд сургуулиудыг төгссөн хүмүүсээс хоёр дахин их.

- Израилийн венчур капиталын үйлдвэрлэл - Израильд одоо хөгжиж буй венчур хөрөнгийн салбарын гарал үүслийг 1993 онд Йозма хөтөлбөр (Еврей хэлээр "Санаачлага") гэж нэрлэсэн Засгийн газрын санаачлагаас эхлэлтэй. Израильд хийсэн гадаадын аливаа хөрөнгө оруулалтын хөрөнгө оруулалтанд татварын хөнгөлөлт үзүүлж, Засгийн газрын хөрөнгөөр хөрөнгө оруулалтаа хоёр дахин нэмэгдүүлэхийг санал болгов. Үүний үр дүнд 1991-2000 оны хооронд Израилийн хувийн хөрөнгө оруулалтын жилийн зардал, бараг бүх хувийнх нь бараг 60 дахин өсч, 58 сая доллароос 3.3 тэрбум доллар болжээ; Израилийн венчур сангийн эхлүүлсэн компаниуд 100-аас 800 болж өссөн; мөн Израилийн мэдээллийн технологийн орлого 1.6 тэрбум доллараас 12.5 тэрбум доллар болж өссөн байна. 1999 он гэхэд Израиль ДНБ-д эзлэх хувийн хөрөнгө оруулалтаараа АНУ-ын дараа хоёрдугаарт бичигджээ.
- Мөн өндөр технологийн үйлдвэрүүдтэй холбоотой өсөлтийн эзлэх хувь хэмжээгээрээ дэлхийд тэргүүлж байна. Израилийн венч капиталын үйлдвэрлэл 70 орчим идэвхтэй хөрөнгө оруулалтын сантай бөгөөд үүнээс Израилийн оффистой 14 олон улсын VC ажилладаг. Нэмж дурдахад, Polaris Venture Partners, Accel Partners, Greylock Partners зэрэг 220 орчим олон улсын сангууд Израильд салбаргүй боловч дотоод мэргэжилтнээрээ дамжуулан Израильд идэвхтэй хөрөнгө оруулдаг. 2009 онд амьдралын шинжлэх ухааны салбар 272 сая доллар буюу нийт хөрөнгийн 24%-ийг бүрдүүлж, програм хангамжийн салбар 258 сая доллар буюу 23%, харилцаа холбооны салбар 219 сая доллар буюу 20%, интернэтийн салбар 13%-ийг тус тус тэргүүлсэн байна.

- Израильд үйл ажиллагаа явуулж буй үндэстэн дамнасан технологийн компаниуд - 2010 оны байдлаар Силикон Вади-д болон Израиль улсад үндэстэн дамнасан судалгаа, хөгжлийн төвүүдэд 35,000 гаруй ажилтнууд ажиллаж байжээ. Сүүлийн жилүүдэд Зүүн Азийн үндэстэн дамнасан болон хөрөнгө оруулагчид, ялангуяа эх газрын Хятад улсаас идэвхтэй хөрөнгө оруулалт хийж, Алибаба, Байду, Тенцент, Куанг-Чи зэрэг Хятадын технологийн аварга компаниуд Израильд салбараа нээн ажиллуулж байна. Гадаадын 60 орчим C&X төвүүд нь биотехнологи, химийн бодис, үйлдвэрийн машин механизм, харилцаа холбооны тоног төхөөрөмж, шинжлэх ухааны багаж хэрэгсэл, эмнэлгийн хэрэгсэл, флэш санах ой хадгалах төхөөрөмж, компьютерийн техник хангамжийн бүрэлдэхүүн хэсэг, програм хангамж, хагас дамжуулагч, интернет зэрэг олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг.

Харин Инновац, технологийн паркууд нь орчин үеийн шинжлэх ухаан, технологийн хөгжилд чиглэсэн, өндөр технологийн шийдлүүдийг хэрэгжүүлж, инновацийн төслүүдийг дэмждэг байгууламжууд юм.

Дэлхий даяар алдартай инновац, технологийн паркуудаас товч дурьдал:

1.Силикон хөндий (Silicon Valley), АНУ

Цахиурын хөндий нь дэлхийн хамгийн том технологи, инновацийн төв бөгөөд АНУ-ын Калифорни мужид байрладаг. Энд Google, Apple, Facebook, Tesla зэрэг дэлхийд танигдсан томоохон компаниуд байрладаг.

2.Zhongguancun технологийн парк, Хятад

Хятадын Zhongguancun технологийн парк нь бээжин хотод байршдаг бөгөөд Хятадын цахиурын хөндий гэж нэрлэгддэг. Энэхүү парк нь орчин үеийн технологи, цахим худалдаа, хиймэл оюун ухаан зэрэг салбаруудын хувьд тэргүүлэгчдийн нэг юм.

3.Шэньжэний инновац, технологийн парк, Хятад

Шэньжэнь бол Хятадын технологийн гол төвүүдийн нэг бөгөөд энэ хотод олон технологийн компаниуд байрладаг. Шэньжэнийн инновац, технологийн парк нь мэдээллийн технологи, цахим төхөөрөмжүүд, робот техник, хиймэл оюун ухаан зэрэг салбарт идэвхтэй ажилладаг.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГААС МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРГАМЖ БА ТУРШЛАГА

Гадаадын паркууд нь дараах түгээмэл шинжтэй байна. Үүнд:

- Томоохон газар нутаг, талбай эзэлдэг.
- Олон тооны АНН, компани, байгууллагыг нэгтгэдэг.
- Олон тооны байнгын ажиллагчидтай.
- Ажиллах хүчнийг хөгжүүлэх, дадлагажуулах талаар сургалтын нэгдсэн системтэй.
- Дэд бүтцийн асуудлыг цогцоор нь шийдсэн.
- Цахилгаан, дулааны эрчим хүч, уур хий, усны хангамжийн эх үүсвэрийг төвлөрүүлэн байгуулсан.
- Санхүү, татварын чиглэлээр янз бүрийн хөнгөлөлт, урамшууллын системтэй.
- Худалдааны чөлөөт бүсийн эрхийг эдэлдэг.
- Судалгаа шинжилгээ, туршилтын хүчирхэг лаборатори, баазтай.
- Хот, орон нутгийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулдаг.
- Паркийн хөгжлийг хангахад чиглүүлэн төслүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлдэг.
- Дэд бүтэц, харилцаа холбоо бусад үйлчилгээгээр паркд хамрагдах нэгж хэсгүүдийг бүрэн хангаж тасралтгүй үйл ажиллагаа явуулах нөхцлөөр бүрдүүлж өгдөг.

- Төр, засгийн зүгээс Паркийн нэгжид хамрагдах үйлдвэрүүдийг орлогын татвар, экспорт, импортын татвар зэргийг хөнгөлөхийн сацуу хөрөнгө оруулалтын таатай нөхцлөөр хангаж чадахуйц механизм үйлчилдэг тул хөрөнгө оруулагчдын сонирхлыг татдаг зэрэг болно. Эдгээр байдлыг судалж, өөрийн орны нөхцөлд тохируулан хэрэгжүүлэх талаар тодорхой бодлого, шийдвэр гаргаж ажиллах нь чухал байна.

Судалгаанаас нэгтгэн дүгнэхэд, судалгаанд хамрагдсан улс орнууд, ШУП-уудын татвар хөнгөлөлтийн бодлогоос үзэхэд манай орны бизнес, эрх зүйн орчинд нийцэхээр дараах төрлийн бодлогын урамшуулалын арга хэлбэрүүд байдаг байна. Үүнд:

- Гадаадын хөрөнгө оруулагчид паркд үйл ажиллагаа явуулж олсон ашгаараа өөрийн компанидаа дахин хөрөнгө оруулж, компанийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж эсвэл өөр нэг компани үүсгэн байгуулж 5-аас доошгүй жил үйл ажиллагаа эрхэлсэн тохиолдолд татварын хэлтэсд өөрөө хүсэлт гарган нэмэлт хөрөнгө оруулснаас хойш төлсөн бүх татварынхаа 30-40%-ийг эргүүлэн авах эрх эдэлнэ.
- Техник, технологио сайжруулахад зарцуулсан хөрөнгө нь өмнөх жилийнхээсээ 10% илүү байвал холбогдох зөвшөөрлийг авсны үндсэн дээр технологийн хөгжилд зарцуулсан бодит зардлын 50%-тай тэнцэх хэмжээгээр тухайн жилд төлөх ёстой татвараа хөнгөлүүлэх эрхтэй.
- Экспортын баримжаатай болон дэвшилтэт технологи үйлдвэрлэдэг компани татварын хуулинд заасан татваргүй бодлого болон татвараас хөнгөлөгдөх бодлогод хамрагдаж, улмаар хуульд заасан хугацаа дууссанаас хойш тухайн жил экспортолсон бараа нийт бүтээгдэхүүний 70%-иас давсан тохиолдолд 10%-ийн татварын хөнгөлөлт эдэлнэ. Дэвшилтэт технологи үйлдвэрлэдэг компани хуулинд заасны дагуу 3 жил 10%-ийн татварын хөнгөлөлт эдэлж болно.

- Үйлдвэрлэл явуулдаг гадаадын хөрөнгө оруулагч компани 10-аас дээш жил үйл ажиллагаа явуулбал ашиг олж эхлэх эхний 2 жилд ямар ч татвар төлөхгүй. 3-5 дахь жилд татвараас 50% чөлөөлөгдөнө.
- Бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компани Хятад улсаас явуулж байгаа хууль дүрмийн татвар төлөхгүй бөгөөд, хуульд заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд тухайн жилд экспортолсон нийт бүтээгдэхүүний хэмжээ тухайн жилд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний 50%-иас давж байвал 50%-ийн татварын хөнгөлөлт эдэлнэ. Мөн орон нутгийн татвараас бүрэн чөлөөлөгдөнө.
- Гадаадын хөрөнгө оруулагч компаниас олсон ашгаараа компанидаа дахин хөрөнгө оруулалт хийж компанийн бүртгэлийн нийт хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх эсвэл бусад гадаадын хөрөнгө оруулалттай өөр нэг компанид хөрөнгө оруулж 5-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсны дараа, татварын хэлтэст өөрөө хүсэлт гарган зөвшөөрөгдсөн тохиолдолд дахин хөрөнгө оруулснаас хойш төлсөн бүх татварынхаа 40%-ийг эргүүлэн авах боломжтой.
- Дахин хөрөнгө оруулалтаараа бүтээгдэхүүн экспортолдог компани эсвэл мэдээллийн технологийн компани байгуулах юмуу өргөтгөж 5-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан бол хөрөнгө оруулснаас хойш төлсөн бүх татвараа эргүүлэн авах боломжтой.
- Гадаадын хөрөнгө оруулалттай пүүс компани хөрөнгө оруулсан эхний 5 жил онцгой урамшуулал эдэлнэ. Мөн орон нутгийн захиргаанаас төлсөн татвараар нь эргүүлэн урамшуулна. Жилд төлсөн татвар нь 500 мянган юаниас доош байвал татварын 30%-иар, түүнээс дээш байвал татварын 40%-иар жилд төлсөн нийт татвар нь 1 саяас давбал татварын 50%-иар эргүүлэн урамшуулж болно.

- Пүүс компаниуд хөрөнгө оруулсан эхний 3 жилд тус Паркийн санхүү татварын хэлтэст татвар төлж эхлэх бөгөөд нийт төвлөрсөн татварын 80%-ийг компанид буцаан олгож, 20%-ийг паркийн удирдлагын зөвлөлд шилжүүлнэ. 4 болон 5 дахь жилд компаниуд татвар төлөх бөгөөд татварын 50%-ийг компаниудад эргүүлэн олгож, 20%-ийн паркийн удирдлагын зөвлөлд шилжүүлнэ. Паркийн удирдлагын зөвлөл хураасан татвараар Паркийн дэд бүтцийг хөгжүүлэхэд ашиглана.
- Паркад элсэн орсон пүүс компани барилга байгууламж барьж, хөрөнгө оруулалт хийж эхэлснээс хойших 3 жилд тус паркийн захиргааны зардлаас бүрэн чөлөөлөгдөнө.
- 10 жилээс дээш үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай компани /үндсэн хөрөнгө 1 сая доллароос дээш байх/ Хятад улсаас явуулж байгаа татварын хөнгөлөлтөд хамрагдах бөгөөд эхний 5 жилд тус паркад төлсөн бүх татварын 60%-ийг, дараагийн 5 жилд төлсөн татварын 40%-ийг эргүүлэн олгоно.
- Шинээр байгуулагдсан эсвэл холбогдох байгууллага тухайн компанийг экспортын компани эсвэл мэдээллийн технологийн компани гэж дүгнэсэн тохиолдолд компани эхний 5 жилд тус паркт төлсөн бүх татварыг, дараагийн 5 жилд төлсөн татварын 60%-ийг эргүүлэн олгоно. Мөн эхний 5 жилд төлсөн нэмүү өртгийн татварын 50%-ийг, дараагийн 5 жилд нэмүү өртгийн татварын 40%-ийн тус тус буцаан олгоно.
- Тус паркт элсэж, мөн паркийн гадна үйл ажиллагаа эрхэлдэг бол 10 жилийн хөнгөлөлт эдлүүлнэ. Компани эхний 5 жилд тус паркад төлсөн бүх татварыг, дараагийн 5 жилд төлсөн татварын 50%-ийг эргүүлэн олгоно. Мөн эхний 5 жилд төлсөн нэмүү өртгийн татварын 50%-ийг, дараагийн 5 жилд нэмүү өртгийн татварын 30%-ийг тус тус буцаан олгоно.

- Тус паркт үйл ажиллагаа явуулж байгаа аливаа пүүс компани цөм татварын хөнгөлөлт эдэлнэ.
- Тус паркт гадаадын төсөл, хөрөнгө зуучлан оруулж ирвэл, тухайн төслийн бодит үр дүнг харгалзан зуучилсан хүнд тухайн төслөөс паркад төлсөн нийт татварын 5-15% -тай тэнцэх мөнгөн урамшуулал олгох зэрэг болно.

**ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ,
ИННОВАЦЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ
ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ**

САЛБАРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН:

Салбарын хэмжээнд дараах хуулиуд байна.

1. Инновацийн тухай хууль, 2012 он
2. Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, 2024 он
3. Технологи дамжуулах тухай хууль, 1998 он
4. Патентын тухай хууль, 2021 он
5. Оюуны өмчийн тухай хууль, 2020 он
6. Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, 2022 он
7. Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013 он

Салбарын хэмжээнд дараах бодлогын баримт бичгүүд батлагдсан гарсан байна.

№	Батлагдсан бодлогын баримт бичгүүд	Хүчинтэй эсэх
1.	Эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд гарааны компани байгуулах журам, Засгийн газрын 2014 оны "Журам батлах тухай " 374 дүгээр тогтоол	Хүчингүй болсон.

2.	Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого, Засгийн газрын 2017 оны 295 дугаар тогтоол	Хүчингүй болсон.
3.	Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого, Засгийн газрын 2018 оны 233 дугаар тогтоол	Хүчингүй болсон.
4.	Үндэсний инновацийн шагнал олгох журам, Засгийн газрын 2018 оны "Журам батлах, шагналын хэмжээ тогтоох тухай " 49 дүгээр тогтоол	Хүчингүй болсон.
5.	Инновацийн үйл ажиллагаанд оролцогчдод грант олгох журам, Засгийн газрын 2018 оны "Журам батлах, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай " 99 дүгээр тогтоол	Хүчингүй болсон.
6.	Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр, Засгийн газрын 2020 оны "Үндэсний хөтөлбөр батлах тухай " 33 дугаар тогтоол	Хүчингүй болсон.
7.	Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэл чиглэл, Засгийн газрын 2020 оны "Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэл чиглэл батлах тухай" 95 дүгээр тогтоол	Хүчинтэй.
8.	Гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн	Хүчинтэй.

	нэгжид дэмжлэг үзүүлэх журам, Засгийн газрын 2023 оны 39 дүгээр тогтоол	
--	---	--

Улсын их хурлаас 2012 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Инновацийн тухай хуулийг батлан дагаж мөрдөж байна. Тус хуулиар инновацийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, төрийн дэмжлэг, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулан эзэмших, ашиглах, эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулдаг. Мөн инновацийн тухай хууль тогтоомжид Монгол Улсын Үндсэн хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай, Дээд боловсролын тухай, Компанийн тухай, Патентын тухай, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актууд орно.

Инновацийн тухай хуулийн нэгдүгээр бүлэгт инноваци, шинэ мэдлэг, инновацийн үйл ажиллагаа, инновацийн бүтээгдэхүүн, инновацийн төсөл, инновацийн грант, гарааны компани, технологийн туршилт, зүгшрүүлэлт, роялти, хөрөнгө оруулалтын компани, менежментийн гэрээ, менежментийн компани, **шинжлэх ухааны парк, паркийн удирдлага, паркийн нэгж**, инновацийн дэд бүтэц, зөвлөх компани гэсэн хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг гаргажээ.

Инновацийн тухай хуулийн хоёрдугаар бүлэгт Инновацийн үйл ажиллагаа, төрийн дэмжлэг, гуравдугаар бүлэгт Инновацийн үйл ажиллагааны удирдлага, төрийн байгууллагын бүрэн эрх, дөрөвдүгээр бүлэгт Шинжлэх ухааны парк, парк байгуулах, паркийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, паркийн удирдлагын чиг үүрэг, паркийн үйл ажиллагааны чиглэлийг тусгажээ.

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинжлэх ухаан, технологийг улс орны тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлсийн нэг болгон хөгжүүлж, үр ашигтай үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэх хэсэгт “Шинжлэх ухаан, технологи, инновацийн тэргүүлэх чиглэлийг

хөгжүүлэх дэд бүтцийг өргөжүүлж, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах тогтолцоотой болсон байна”, “2.4.9.Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэхэд шаардлагатай шинжлэх ухааны парк, инновацийн татваргүй бүсийг хамтын оффист түшиглэн байгуулна.” гэж;

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай, УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын “Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт”, “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт”-д, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.7.6-д “Инновацын хөрөнгө оруулалтын сан, технологийн парк байгуулан шинжлэх ухаан, хиймэл оюун ухаан, дижитал бизнес, ногоон төсөл, бүтээмжийн зах зээлийг дэмжих гарааны хөрөнгө оруулалт, техникийн туслалцааны инкубатор санг хөгжүүлэх” гэж, 3.3.7.4-т “Мэдээллийн технологи, судалгаа хөгжүүлэлт, инновацын үйл ажиллагаа эрхлэх татварын хөнгөлөлттэй чөлөөт бүс, шинжлэх ухааны паркийг хөгжүүлнэ.” гэж тусгагдсан.

Шинжлэх ухаан, технологи, инновацийн үндэсний бодлого нь шинжлэх ухаан, технологи, инновацийн улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийн талаарх Засгийн газрын алсын харааг илэрхийлдэг.

Түүнчлэн Монгол улсын Засгийн газраас инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, Инновацийн тухай хуулинд Шинжлэх ухааны парк байгуулах, паркийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, паркийн удирдлагын чиг үүрэг, үйл ажиллагааг тусгасан нь улс орны нэн тэргүүний ажил гэж үзсэнтэй холбоотой юм.

Засгийн газрын 2020 оны "Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл батлах тухай" 95 дугаар тогтоолоор Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл батлагдсан.

Мөн Засгийн газрын 2023 оны 39 дүгээр тогтоолоор "Гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх журам" батлагдсан.

Инновацийн тухай хуульд шинжлэх ухааны паркийн асуудал туссан боловч паркийн амин сүнс болох гарааны компани байгуулах үйл явц, төрөөс үзүүлэх дэмжлэгийн төрлийн талаар дагалдах дүрэм журмын зохицуулалт тодорхойгүй байх бөгөөд венч хөрөнгө оруулалтын сангийн тухай заалтыг хассан нь шинжлэх ухааны парк байгуулах боломжийг хязгаарласан байна.

Түүнчлэн паркийн үйл ажиллагааны чухал оролцогч болох гаднын хөрөнгө оруулагчид, судалгааны болон бизнесийн зөвлөх, экспертүүдэд үзүүлэх хөдөлмөр эрхлэх, оршин суух зөвшөөрөл олгох асуудлыг хөнгөвчлөх, эдийн засаг татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг чухал асуудлуудыг зохицуулах эрхзүйн орчин хангалтгүй буюу байхгүй байна.

Парк гэдэг талаасаа Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуультай төстэй боловч зохицуулалтын хувьд өөр байна.

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль нь үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих орчныг бүрдүүлэх, ажлын байр бий болгох, байгаль орчинд халгүй үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилготой бол Шинжлэх ухаан, технологи, инновацын парк нь инноваци, гарааны бизнесийн хөгжих орчныг бүрдүүлэх, мэдлэгт суурилсан инновацийн бизнесийг дэмжих орчин бий болгох үйл ажиллагаа, салбар хоорондын ялгаатай эрх зүйн харилцааг зохицуулах юм.

Агуулгын хувьд инновацын дэд бүтцийг хөгжүүлэх зорилго ижил боловч Инновацийн тухай хуулинд нэршлийн хувьд шинжлэх ухааны парк гэж зааж өгсөн нь инновац, технологийн парк байгуулахад бэрхшээл учруулж байна.

Шинжлэх ухааны парк байгуулах эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн гэж үзэж болно. Тухайлбал Инновацийн тухай хуулиас гадна дараах бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан.

Шинжлэх ухаан, технологи, инновацын парк гэж юу вэ?

Хөгжингүй эдийн засагтай орнууд 1970-аад оноос хойш шинжлэх ухааны паркуудыг төлөвлөх, байгуулах төслүүдийг бий болгож байна. Тэд 1970 оны нефтийн хямралын дараа инновацийн нэн чухал ач холбогдлыг ойлгож, шинжлэх ухааны паркууд түүнийг хэрэгжүүлэх боломжит хэрэгсэл болж гарч ирсэн. Эдгээр паркууд нь зөвхөн эдийн засагт үр өгөөжөө өгөөд зогсохгүй орон нутгийн болон олон улсын түвшинд инновацийг нэвтрүүлэхэд тус дөхөм болсон.

НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын (ЮНЕСКО) мэдээлснээр дэлхий даяар 400 гаруй Шинжлэх ухаан, технологи, инновацын парк байдаг бөгөөд тэдний тоо нэмэгдсээр байна. Америкийн Нэгдсэн Улс 170 гаруй шинжлэх ухааны паркаараа тэргүүлж байгаа бол Япон 111 Шинжлэх ухаан, технологи, инновацын паркаараа удаалж байна. Хятад улс 1980-аад оны дунд үеэс шинжлэх ухааны паркуудыг хөгжүүлж эхэлсэн бөгөөд өдгөө 100 орчим болжээ. Энэхүү тархалт нь дэлхийн хэмжээнд Шинжлэх ухаан, технологи, инновацын паркуудыг хүлээн зөвшөөрч буйг харуулж байгаа бөгөөд ирээдүйн эдийн засгийн өсөлт, өрсөлдөх чадвар нь шинжлэх ухаан, технологи, инновацын паркуудаар дамжуулан инновацид тулгуурласан хүчирхэг эдийн засгийг бий болгох явдал гэдгийг харуулж байна. Энэтхэг, Иран, Египет, Марокко, Тунис болон бусад олон улс Шинжлэх ухаан, технологи, инновацын паркуудыг нэгтгэснээр бүс нутгийн инноваци, эдийн засгийн хөгжлийг дэмжиж, улмаар хэдэн мянган шинэ ажлын байр, судалгаа, боловсруулалтын боломж, бизнес эрхлэх, жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ) бий болсон. Мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХТ)-ийн үүрэг роль нэмэгдэж байна.

Шинжлэх ухаан, технологи, инновацын парк нь мэдлэгийг хуваалцах, инновацийг сурталчлах, судалгааны үр дүнг ашигтай арилжааны бүтээгдэхүүн болгон ахиулах боломжийг олгодог. Энэ нь үндэсний эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж, шинэ өндөр технологийн пүүсүүдийг бий болгоход түлхэц өгч, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, экспортыг дэмжих зорилготой гэж үздэг.

Дэлхийн хамгийн анхны их сургуулийн судалгааны парк болох Стэнфордын судалгааны парк нь 1951 онд Стэнфордын их сургууль болон Пало Алто хотын хамтын ажиллагааны хүрээнд байгуулагдсан.

Шинжлэх ухаан, технологи, инновацын паркууд нь дэлхийн "мэдлэгийн эдийн засгийн" дэд бүтцийн элементүүд юм. Эдгээр нь инноваци, технологийг хөгжүүлэх, арилжаалахад түлхэц өгөх, засгийн газар, их дээд сургууль, хувийн компаниуд хамтран ажиллах боломжтой дэд бүтцээр хангадаг.

Шинжлэх ухаан, технологи, инновацын паркууд нь судлаач, хөгжүүлэгчдад зориулсан бүс, өндөр технологи, үйлдвэрлэлийн бүс, бизнес инкубатор, хурдасгуур хөтөлбөр, хамтын ажиллагааны үйл ажиллагаа, дэд бүтцийн хангамж, харилцаа холбооны зангилаа, захиргааны оффис болон нийгмийн хэрэгцээг хангах орон сууц, эмнэлэг, банк, зогсоол, нийтийн тээвэр, ресторан, сургууль цэцэрлэг бүхий боловсролын бүс, спорт, амралтын бүстэй, ирээдүйд өргөтгөх газар нутагтай байдаг.

Шинжлэх ухаан, технологи, инновацын паркууд нь илүү зохион байгуулалттай, төлөвлөлттэй, удирддаг гэдгээрээ өндөр технологийн бизнесийн бүсүүдээс ялгаатай. Тэд судалгааны үр дүнг арилжааны бүтээгдэхүүнд хүргэдэг гэдгээрээ шинжлэх ухааны төвүүдээс ялгаатай. Эдгээр нь үйлдвэрлэлд төвлөрсөн аж үйлдвэрийн паркууд болон удирдлагад төвлөрсөн бизнесийн паркуудаас ялгаатай.

Сүүлийн 11-12 жилийн хугацаанд Европын Холбооны хэмжээнд шинжлэх ухаан, технологийн паркийн (STP) үйл ажиллагаа ойролцоогоор хоёр дахин нэмэгдсэн байна. Одоогийн байдлаар ЕХ-ны гишүүн орнуудад 28 сая м2 ашиглалтад орсон барилгын талбайг удирдаж буй 366 парк байдаг бөгөөд 40,000 орчим байгууллага 750,000 орчим хүнийг ажлын байраар хангаж ихэвчлэн нэмүү өртөг өндөртэй ажлын байр байдаг. 2000-2012 оны хооронд ЕХ-ны STP-д оруулсан нийт хөрөнгийн хөрөнгө оруулалт ойролцоогоор 11.7 тэрбум евро (төв тооцоолол) байна. Шинжлэх ухаан, технологи, инновацын парк нь их сургууль, судалгаа хөгжлийн хүрээлэн, компани, зах зээл тэдгээрийн хоорондох технологи болон мэдлэгийн урсгалыг удирдаж, зохицуулдаг бөгөөд инкубаци, хувь нийлүүлсэн шинэ охин компаниар (spin off) дамжуулан компаниудыг шинээр бий болгож, тэдгээрийн өсөн дэвжих үйл ажиллагааг дэмждэг.

Шинжлэх ухаан, технологи, инновацын парк нь шинжлэх ухаан болон технологийг эдийн засгийн эргэлтэнд оруулах, өндөр технологид суурилсан аж үйлдвэрүүдийг дэмжихэд чиглэгдсэн байгууллага юм. Гол зорилго нь Засгийн газрын байгууллагууд, бизнесийн дэмжлэг, хөгжлийн хөтөлбөрүүдийг нэг дор цуглуулан “мэдлэгт суурилсан эдийн засгийн өсөлтийг хангах”-д чиглэдэг.

Шинжлэх ухаан, технологи, инновацын паркийн үйл ажиллагаа амжилттай бөгөөд тасралтгүй хэрэгжихэд дараах нөхцлүүдийг бүрдүүлэх шаардлагатай байдаг. Үүнд:

- **Бизнес инкубатортай байх** – авъяас, технологи, вэнч капитал, ба мэргэжлийн бизнесийг хооронд нь холбож, хуулийн зөвлөгөө өгөх зэргээр инновацийг дэмжиж, эрсдлээс сэргийлэх
- **Их сургуулийн хамтын ажиллагаа** – мэдлэг мэдээллээс хараат бөгөөд их сургуульд явагдаж буй судалгааны ажлаас шинэ санаа, шилдэг ажилтан төрөн гарч ирнэ

- **Их сургууль, бизнес ба олон нийтийн гурвалсан түншлэл** – мэдлэг дамжуулах, шинэ бизнес төрүүлэхэд чухал
- **Инновацийн соёл** – компаниуд инновацийн соёлтой, эрсдэлээс эмээдэггүй байдал нь нэг нэгэндээ урам хайрлаж, хүрээллийн гадна болон дотно мэдлэг дамжих хүчин зүйл болдог
- **Аж үйлдвэрийн кластер** – энэ нь бие даасан бизнес, судалгааны институт, боловсролын төв, мэдлэг үйлдвэрлэгч компани зэргийн сүлжээ бөгөөд нэмүү өртөг шингээсэн үйлдвэрлэлийн сүлжээг хэрэглэгчтэй холбож, техникийн болон бизнесийн зөвлөхүүдийн хамтрагч болгодог.
- **Соёлын үйлчилгээ** – Нийгмийн болон соёлын үйлчилгээг нэгэн зэрэг өндөр түвшинд хүргэж, гэр бүлийн амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлсэн орчинг бий болгох
- **Мэдлэгийн хот** – дотроо судалгаа ба инновацийг арилжаатай хослуулсан хэлбэр бүхий – шинэ хот нь тохилог орчин бүрдүүлээд зогсохгүй дэлхийн бизнесийн болон шинжлэх ухааны хүрээлэлтэй холбогдсон байх
- **Тээвэр, сүлжээ** – нийтийн тээвэр, дотоод гадаадын төмөр зам, хотоос гарч орох төрөл бүрийн бүтэц – жишээ нь олон улсын нисэх буудал, судлаач/бизнес эрхлэгч/эрдэмтэд хоорондоо тааралдаж танилцаж нөхөрлөх боломж олгох явган явах цэцэрлэгт хүрээлэн,
- **Дэмжлэг үзүүлэх байгууллагууд** – вэнч хөрөнгө оруулагчид, бизнесийн болон санхүүгийн зөвлөхүүд, тухайлсан аж үйлдвэрийн салбарт маркетингийг нь хийх, шинээр гарааны компани байгуулах, хөрөнгийн эх үүсвэрийг шийдэх, хуулийн болон бизнесийн зөвлөгөө өгөх зэрэгт мэргэшсэн компани
- **Барилга байгууламж, уян хатан нөхцөл** – шинэ компани түрээслүүлэх тохиромжтой, уян хатан нөхцөлтэй байр, лаборатори, үйлдвэрлэлийн болон хүргэлтийн үйлчилгээ авах боломжтой

- **Технологийн дэд бүтэц** – Олон улсад хамтын ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх, дотоод гадаадын судлаачид хамтын ажиллагаанд ашиглах боломжтой хүчтэй төхөөрөмжтэй, сүлжээтэй байх,

Олон нийтийн оролцоо – тасралтгүй мэдлэгийг бий болгоход үүрэг гүйцэтгэдэг.

Шинжлэх ухаан, технологийн паркийн үйл ажиллагааны чиглэл, цар хүрээнээс шалтгаалан шинжлэх ухаан, технологийн парк, судалгааны парк, инновац, технологийн парк, био парк, технопарк, технополис, технополь, Шинжлэх ухааны хот, Шинжлэх ухааны тосгон гэх мэт нэрлэдэг.

**ИННОВАЦ, ТЕХНОЛОГИЙН ПАРК, ШИНЖЛЭХ УХААНЫ ПАРК
ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК
ХООРОНДЫН ЯЛГАА**

<u>№</u>	<u>Харьцуулах үзүүлэлт</u>	<u>Шинжлэх ухааны парк</u>	<u>Үйлдвэрлэл технологийн парк</u>	<u>Инновац, технологийн парк</u>
1.	Оролцогчид	Их дээд сургууль, судалгааны байгууллага, технологийн компаниуд	Үйлдвэрлэгчид, технологийн компаниуд, ханган нийлүүлэгчид	Гарааны бизнес, ЖДҮ, томоохон аж ахуйн нэгж, судалгааны хүрээлэнгүүд
2.	Хүний нөөц	Инженер, техникийн ажилтнууд, үйлдвэрлэлийн дизайнерууд, R&D ажилтнууд	Эрдэмтэд, судлаачид, эрдэмтэн судлаачид, R&D мэргэжилтнүүд	Бизнес эрхлэгчид, инженерүүд, бизнес хөгжүүлэгчид, судлаачид
3.	Бүтээгдэхүүн	Шинжлэх ухааны нээлт, патент, прототип	Аж үйлдвэрийн технологи, үйлдвэрлэлийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, боловсорсон бүтээгдэхүүн	Технологи, программ хангамж, бизнесийн загвар, үйлчилгээ
4.	Бүтээгдэхүүний цикл	Илүү урт мөчлөг (судалгаа, туршилт, зохицуулалтын зөвшөөрөл)	Богино мөчлөг (хурдан үйлдвэрлэл, масштаб)	Өөр өөр байдаг (шинэчлэлээс хамааран богино эсвэл урт мөчлөг)
5.	Зорилго	Шинжлэх ухааны судалгааг дэмжих, мэдлэгийг дээшлүүлэх	Үйлдвэрлэлийн процессыг сайжруулж, үйлдвэрлэлийг сайжруулнабий болгох.	Төрөл бүрийн инновацийг дэмжих, бизнес эрхлэхийг дэмжих

Үйлдвэр технологийн парк, шинжлэх ухааны парк, инновацийн парк гэсэн нэр томъёонууд нь эдийн засгийн хөгжил, судалгаа, хамтын ажиллагааг дэмжих зорилготой тусгай орон зайг хэлж байгаа боловч тус бүр нь өөр өөр чиг үүргийг гүйцэтгэж, хөгжлийн тодорхой талуудад төвлөрдөг.

1. Үйлдвэрлэл технологийн парк

Үйлдвэрлэлийн технологийн парк нь аж үйлдвэрийн салбарт дэвшилтэт технологийг хөгжүүлэхэд чиглэдэг. Эдгээр паркууд нь ихэвчлэн үйлдвэрлэл, судалгаа, үйлдвэрлэлийн технологийн хөгжлийг дэмжих зорилготой байдаг. Компаниудад үйлдвэрлэлээ өргөжүүлэх, үйлдвэрлэлийн процесстоо шинэчлэл хийх, янз бүрийн салбарт (жишээ нь: робот техник, электроник, автомашин, биотехнологи гэх мэт) өндөр технологийн шийдлүүдийг хэрэгжүүлэх боломжийг олгоход анхаардаг.

Гол шинж чанарууд:

Төвлөрөл: Гол төлөв аж үйлдвэр, үйлдвэрлэлийн салбарт төвлөрдөг.

Үндсэн түрээслэгчид: Үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн технологид оролцдог компаниуд.

Зорилго: Үйлдвэрлэлийн үр ашгийг бий болгож, үйлдвэрлэлийн технологийн дэвшлийг дэмжих, аж үйлдвэрийн инновац ашиглан эдийн засгийн өсөлтийг дэмжих явдал юм.

Байгууламж: Үйлдвэрлэлийн байгууламж, R&D төвүүд, төрөлжсөн үйлдвэрлэлийн дэд бүтэц багтаж болно.

2. Шинжлэх ухааны парк

Шинжлэх ухааны парк нь ихэвчлэн амьдралын шинжлэх ухаан, биотехнологи, байгаль орчны шинжлэх ухаан, инженерчлэл зэрэг өндөр

технологийн салбарт шинжлэх ухааны судалгаа хийх, шинэ нээлтүүдийг арилжаанд оруулахыг чухалчилдаг судалгаа, хөгжлийн төв юм.

Шинжлэх ухааны паркад ихэвчлэн шинжлэх ухааны мэдлэгийг дээшлүүлэх, түүнийг шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хөгжүүлэхэд чиглэсэн судалгааны байгууллага, их дээд сургууль, гарааны бизнес эрхлэгчид байрладаг.

Гол шинж чанарууд:

Төвлөрөл: Шинжлэх ухааны судалгаа, хөгжил (R&D), ихэвчлэн амьдралын шинжлэх ухаан, физик, инженерчлэл зэрэг салбарт төвлөрдөг.

Үндсэн түрээслэгчид: Их дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, стартапууд, шинжлэх ухааны судалгаа, хөгжүүлэлт хийдэг компаниуд байдаг.

Зорилго: Шинжлэх ухааны ололт амжилтыг арилжаанд оруулах, академи болон үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг дэмжих, шинэ технологийн хөгжлийг хурдасгах явдал юм.

Байгууламж: Лабораториуд, тохилог өрөө, судалгааны байгууламж, эрдэм шинжилгээний болон үйлдвэрлэлийн хамтын орон зай байдаг.

3. Инновац, технологийн парк

Инновац, технологийн парк нь аж үйлдвэрийн технологийн парк болон шинжлэх ухааны паркийн элементүүдийг хослуулдаг. Гэхдээ бүтээлч байдал, бизнес эрхлэлт, хамтын ажиллагааг дэмжихэд илүү их анхаарал хандуулдаг илүү өргөн хүрээтэй, илүү хүртээмжтэй ойлголт юм.

Инновацийн паркууд нь олон төрлийн үйлдвэрлэл, технологийг дэмжих зорилготой бөгөөд ихэвчлэн технологийн стартапууд, томоохон компаниуд, судалгааны байгууллагуудыг хамардаг. Эдгээр паркууд нь шинэ санааг ашигтай бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хувиргахад чиглэдэг бөгөөд ихэвчлэн салбар хоорондын хамтын ажиллагааг дэмжих орчинг бүрдүүлэх зорилготой.

Гол шинж чанарууд:

Төвлөрөл: Технологи, бизнесийн ашигтай загвар, инновац шингэсэн үйлчилгээ зэрэг олон салбарыг хамардаг.

Үндсэн түрээслэгчид: Салбар бүрийн гарааны бизнес, томоохон аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээний байгууллагууд, R&D төвүүд байдаг.

Зорилго: Салбар бүрийн стартап компани болон аж ахуйн нэгжүүд, судалгааны байгууллагуудын хамтын ажиллагааны замаар инновацын хөгжлийг дэмжих зорилготой. Ихэнхдээ бизнес эрхлэх, технологи дамжуулахыг дэмждэг.

Байгууламж: Хамтран ажиллах орон зай, инкубатор төв, хурдасгуур төв, R&D төв, уулзалтын өрөө, заримдаа бүр гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан орон сууц зэрэг багтдаг.

Парк бүр нь инноваци, технологийн янз бүрийн талыг хөгжүүлснээр бүс нутаг эсвэл үндэсний эдийн засгийн хөгжлийг ахиулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Манай улсад шинжлэх ухаан, технологи, инновацын парк байгуулах дараах 3-н үндсэн үндэслэл шаардлага байна.

1. Өнөөгийн нийгэмд хэрэглэгчийн цаг хугацааг хэмнэсэн, хүний нарийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, ухаалаг, **инновац шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт нэмэгдсэн буюу инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлийн хэмжээ өссөн**. Бүр уламжлалт масс бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээнд хүртэл шинэ мэдлэг шингээж шинэ болон инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх болсон. Дотоод зах зээлийн багтаамж бага манай орны хувьд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох

замаар хөрш зэргэлдээ орнуудын зах зээлд олон хэрэглэгчтэй болох нь онцгой ач холбогдолтой.

2. **Шинжлэх ухаан, технологи, инновацын парк нь гадаадын хөрөнгө оруулалт татах нэг чухал хэлбэр** болно. 1990 оны байдлаар дэлхийн үйлдвэрлэл, инноваци, шинжлэх ухааны тэргүүлэх улс орнууд ДНБ-ий 1,5 хувийг судалгаа ба хөгжилд зарцуулдаг байсан бол өнөөдөр 2-5 хүртэл хувийг зарцуулдаг болсон. Үүний дотор хувийн хэвшил үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчдийн судалгаа туршилт, инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжүүлэлтэд зарцуулах хөрөнгө оруулалт эрс нэмэгдсэн байна. Бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сайжруулах, шинэ бүтээгдэхүүн гаргахад шаардлагатай судалгаа шинжилгээнд хөрөнгө зарцуулахгүйгээр аливаа компани, улс орон зах зээлд бүтээгдэхүүнээ борлуулах, бүтээгдэхүүн нь өрсөлдөх чадвартай байх боломжгүй болж байна.

Нэгэнт инновацын бүтээгдэхүүний зах зээлийн бодит эрэлт хэрэгцээ байгаа учир энэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээнд хөрөнгө оруулах сангууд, венч хөрөнгө оруулагчид хөрш орнуудад төдийгүй манай улсад үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна. Түүнчлэн манай улсын гадаад худалдааны тэнцлийг сайжруулж дэлхийн болон бүсийн эдийн засгийн аливаа хямралд өртөхгүй байх дархлааг бий болгох шаардлагын улмаас паркуудыг байгуулан хөгжүүлэх хэрэгцээ шаардлага ч буй.

3. Инновацийн шинэ бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгоход **уламжлалт мэдлэг, эх орны түүхий эдийн давуу талаа ашиглан оролцох боломж** байна. Тухайлбал, манай орны түүхий эдийг ашигласан эсвэл манай судлаачдын нэгэнт бий болгосон, мэдлэг инноваци шингээсэн зарим бүтээгдэхүүн, үйлчилгээг улам хөгжүүлж дэлхийн зах зээлд гаргах бололцоотой. Өнөөгийн санхүү, хөрөнгө оруулалт, инновацийн хөгжүүлэлт, судалгаа, хамтын ажиллагааны хувьд саланги тусдаа явагдаж буй үйл ажиллагааг нэг дээвэр дор оруулах парк, инновацийн төвүүдийг байгуулах

замаар дэлхийн зах зээлд гарах, өрсөлдөх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгож чадна.

Шинжлэх ухаан, технологи, инновацын парк нь эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, бүтцийг шинэчлэх, улсын болон бүс нутгуудын түвшинд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах алс хэтийн үр нөлөөтэй, онцгой ач холбогдолтой болохыг олон улсын туршлагууд ч харуулдаг.

“Шинжлэх ухаан, технологи, инновацын парк байгуулагдаж бүтээлч судалгааны баг, хөрөнгө оруулагчид, үйлдвэр аж ахуйн нэгжүүд, инновацийн үйл ажиллагааг дэмжих, зуучлах дараах нэгжүүд нэг дор байршсанаар бүс нутгийн төдийгүй улс орны эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх өрсөлдөх чадвар нэмэгдэж, иргэдийн амьдрал ахуй дээшлэхээс гадна паркийн үйл ажиллагаанд оролцогч судлаачид, бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдын хувьд дараах нийтлэг давуу нөхцөл, боломж нээгддэг гэж үздэг.”

Үүнд:

Судалгааны баг, судлаачдын хувьд:

- Судалгааны үр дүн эдийн засгийн эргэлтэд оруулах;
- Салбар дундын судалгааны үйл ажиллагааг идэвхижүүлэх, энэ нь орчин цагийн хэрэглэгчийн олон талт хэрэгцээг давуу байдлаар хангах;
- Судлаач роялти болон гэрээний бусад хэлбэрээр судалгааны үр дүнгээс ашиг хүртэх боломжтой болох;
- Эрдэмтэн судлаачдын хамтын ажиллагаа, бүтээлч хариуцлагатай, урам зоригтой байх байдал нэмэгдэх;

Хөрөнгө оруулагчдын хувьд:

- Шинэ бизнес, бизнесийн шинэ салбар эхлүүлэх боломж нээгдэх;

- Үйлдвэрлэл эрхлэх гарааны үйл ажиллагаанд зориулагдах зардал буурах;
- Дэд бүтцэд холбогдсон газрыг элдэв нэмэгдэлгүй, хөөсгүй үнээр худалдан авах, түрээслэх, ашиглах боломж нээгдэх;
- Албан ёсны зөвшөөрөл, баталгаа, эрхийн бичиг авахтай холбогдсон хуулийн болон бусад зөвлөгөөг паркийн удирдлагаас авах бүрэн эрхтэй болох;
- Тоног төхөөрөмж болон үйлдвэрлэл, дэд бүтцийн шинэчлэлд зориулан санхүүгийн дэмжлэг туслалцаа авах, татвар санхүүгийн хөнгөлөлт эдлэх;
- Бизнесийн эрсдэл буурах;

Бизнес эрхлэгчдийн хувьд:

- Паркад багтах компаниудын ажлын бүтээмж нэмэгдэх;
- Талуудын хамтын ажиллагааны дүнд ажлын идэвх, урам зориг нэмэгдэх, бизнесийн нэр хүнд өсөх;
- Газар түрээслэх, хөлслөх таатай нөхцөл бүрдэх;
- Үйлдвэрийн байр, талбай, ус, цахилгаан, шугам сүлжээ, зам, тээвэр холбоо зэрэг дэд бүтцээр бүрэн хангагдах;
- Албан газар, ахуйн үйлчилгээний газар болон паркийн оршин суугчдын зайлшгүй хэрэгцээ болсон бусад үйлчилгээ тухайлбал шуудан, эмнэлэг зэрэг нийтийн эзэмшлийн үйлчилгээгээр авах;
- Бизнес төлөвлөлт, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, төсөл хөтөлбөр, маркетинг, тээвэрлэлт, хөндлөнгийн хяналт, нягтлан бодох бүртгэлийн талаар зөвлөгөө, мэдээлэл хөнгөлөлттэй авах боломж;

Паркийг хөгжүүлэх нь хамтын ажиллагааг бодитойгоор хөгжүүлэх, компани, ААН-үүдэд нилээд олон давуу талыг үүсгэдэг. Үүнд:

- Компаниуд, судалгааны байгууллагууд, зуучлагчид хамтарч ажилласнаар богино хугацаанд хөрөнгө мөнгө, нийлүүлэгчиддээ ойртож улмаар үйлдвэрээ өндөр үр ашигтайгаар ажиллуулах боломж бүрддэг.

- Учир нь паркийн бүтцэд судалгааны хүрээлэн, лаборатори, үйлдвэрлэлийн төв, бүтээмжийн төв төдийгүй бизнес хөгжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд багтдаг;
- Компаниуд болон судалгааны хүрээлэнгүүд хамтарснаар сурах, судлах, шинийг санаачлах, мэдээлэл харилцан солилцох таатай орчин бүрддэг;
- Парк дахь компаниудын төлөвшил илүү өндөр түвшинд хүрдэг;
- Компани, үйлдвэрлэгчид болон тэдэнд үйлчилгээ үзүүлэх бусад байгууллагууд нэг дор байршсанаар хөрөнгө оруулагчдын сонирхлыг илүүтэй татдаг;

Парк байгуулах хэрэгцээ:

Эдийн засгийн төрөлжилт бий болгох, бүс, орон нутгийн хөгжлийг эрчимжүүлэхийн тулд олон улсад тогтсон хамгийн үр ашигтай дэд бүтцийн хэлбэр бол шинжлэх ухаан, технологи, инновацын парк юм.

Өндөр технологийн салбар нь харьцангуй бага нөөцөөр аж үйлдвэрлэл явуулдаг ч улс орны эдийн засгийн өсөлтөд их хувь нэмэр оруулж байдаг. Тухайлбал АНУ-ын өндөр технологийн үйлдвэрлэлийн өлгий Калифорни мужийн Цахиурын хөндийн 2.4 сая орчим оршин суугчид АНУ-ын хүн амын нэгээс бага хувийг эзлэх ч улсынхаа ДНБ-ний 5 хувийг бүтээж байдаг бол Нидерланд улсын өндөр технологийн хот Айндоховенд оршин суугчид (700.000 хүн) нийт хүн амынхаа 4 хувийг эзлэх ч 2011 онд улсынхаа нийт экспортын 25 хувь буюу 55 тэрбум еврог бүтээжээ.

Иймээс хvн ам цөөтэй Монгол Улсын хувьд өндөр технологийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх шаардлага зайлшгүй тулгараад байна.

Автоматажсан, цалин өндөртэй, цөөн хүн ажилладаг, бүтээгдэхүүн нь жин багатай, өртөг их шингээсэн өндөр технологийн салбар нь манай орны хувьд тохиромжтой бөгөөд түүхий эд бага шаардах, сайн тоноглогдсон орчин үеийн

лаборатори, өндөр мэдлэгтэй ажиллах хүчинд түшиглэсэн парк байгуулах нь **“Монгол Улсын хөгжлийг хурдасгах, шинэ түвшинд аваачих, дэлхийн хөгжилтэй улс орнуудтай эн зэрэгцэн алхах гарц юм.”**

Манай Улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт шинжлэх ухааны парк байгуулах хөгжүүлэх тухай тодорхой зорилго, зорилтыг дэвшүүлсэн;

Шинжлэх ухаан, технологи, инновацын парк байгуулах нь тогтвортой хөгжлийн үндсийг бүрдүүлж, бүтээлч мэдлэг үйлдвэрлэлийн ажлын байр, энтрепренерүүдийг бий болгож, улмаар шинжлэх ухаан, инноваци, аж үйлдвэр, хөгжлийн нэгэн загвар хот бий болох боломжийг бүрдүүлнэ.

ДӨРӨВ. ПАРК ДАХЬ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХЭМЖЭЭ, ХУДАЛДААНЫ ЭРГЭЛТИЙН ТААМАГЛАЛ

Паркийн амжилтын чухал хүчин зүйлсийн тодорхойлолт

1. Паркийн удирдлага, менежмент

- Парк төлөвлөлт, бүтээн байгуулалт, менежмент, ашиглалтын заавар
- Чадварлаг, чанартай удирдлага, зохион байгуулалт
- Дээд удирдлагын тууштай байдал, дэмжлэг
- Паркийн зорилго, зорилт, тулгамдсан асуудлыг тодорхой илэрхийлэх чадвар
- Эдийн засгийн хөгжлийн урт хугацааны төлөвлөгөө, стратеги
- Паркт байрлах аж ахуйн нэгжүүдэд таатай орчин бүрдүүлэх
- Төслийн бодитой, сайн төлөвлөгдсөн хуваарь, нөөцийн зохистой хуваарилалт.

2. Дэд бүтэц, байршил

- Физик дэд бүтэц, тээвэр, компаниудыг суурилуулах үйлчилгээ
- Нийгмийн дэд бүтэц, харилцан үйлчлэлийн орчин, оролцогч талуудад тавигдах шаардлага

- Мэдлэгийг түгээхэд тустай харилцаа холбооны дэд бүтэц, өндөр технологи
- Газарзүйн хувьд ойр байх, инноваци, орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих

3. Инноваци, энтерпренёршипийн эдийн засгийн орчин

- Бүс нутаг, үндэсний болон олон улсын инновацийн бодлогыг хэрэгжүүлэх
- Хамтран ажиллах замаар инноваци, бизнес эрхлэх соёлыг төлөвшүүлэх
- Хэмжээ, сегментийн хувьд динамик, олон янзын компаниуд байгаа эсэх
- Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих, эдийн засгийг төрөлжүүлэх
- Технологийн өөрчлөлт, ажлын байр нэмэгдүүлэхэд анхаарлаа хандуулах
- Шинэ бизнес, компаниудыг татах, R&D хөрөнгө оруулалт
- Хүмүүс ба бизнес хоорондын харилцааг бий болгох таатай орчин
- Эрдэм, технологи, эдийн засгийн орлогын хөгжил

4. Эдийн засаг, санхүү, урамшууллын хүчин зүйлүүд

- Санхүүгийн урамшуулал: санхүү, татаас авах, татвараас чөлөөлөх гэх мэт.
- R&D тоног төхөөрөмж, мэргэшсэн боловсон хүчин
- Паркийн бүтээн байгуулалт, ашиглалтын явцад шаардагдах хөрөнгө
- Түрээслэгчдээ амьд үлдэх, өсөхөд шаардагдах янз бүрийн төрлийн санхүүжилт, санхүүгийн эх үүсвэрийг ойлгож, хөнгөвчлөх хариуцлага
- Шинэ хөрөнгө оруулалт татах эдийн засаг-санхүүгийн загварчлалын уян хатан байдал.

5. Бизнесийн үйлчилгээ ба дэмжлэг

- Инкубацийн компаниуд болон паркийн өсөлтийг хангах үйлчилгээ
- Инкубацийн болон бизнесийн сургалт, сүлжээг бүхэлд нь өртгийн сүлжээгээр дэмжих
- Шинжлэх ухааны паркийн гадна болон доторх бизнесийн боломжуудыг олж авах
- Сургалт, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг дэмжих
- Санхүүгийн дэмжлэг, нөөцийн менежментийн үйлчилгээг санал болгох
- Стратегийн төлөвлөлт, бизнес төлөвлөгөө, маркетинг, борлуулалт, санхүү, нөөцийн менежментийн бизнесийн менежментийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх
- Технологийн дамжуулалт, инновацийн менежментийн чиглэлээр мэргэшсэн цөм
- Мэргэшсэн мэргэжилтнүүд, мэргэшсэн ажлын боломжийг бий болгох

6. Соёл

- Мэдлэг солилцох, үр дүнтэй сүлжээг бий болгох орчин
- Байршиж буй бүс нутгийн онцлог, соёлыг хүндэтгэх
- Менежерүүдийн хоорондын идэвхтэй харилцаа нь үр дүнтэй маркетинг, боломжуудыг баталгаажуулдаг
- Паркийн оролцогчид болон түрээслэгчдийн хоорондох үр дүнтэй харилцан хамаарал
- Технологийн эрэл хайгуул, судалгаа ба зах зээлийн хоорондын уялдаа холбоог чухалчилдаг
- Технологийн паркийн оролцогчдын хамтын алсын хараа, мэдээлэл солилцох
- Оролцогч талуудын хоорондын итгэлцэл, харагдах байдал, харилцан үйлчлэл, харилцаа холбоо

7. Оролцогч талуудын нөлөө

- Хүчирхэг, эрч хүчтэй, тогтвортой эдийн засгийн оролцогчдын дэмжлэг
- Санхүүжилтийн агентлагууд, улс төрийн институциуд, бүс нутгийн болон үндэсний хөгжлийн байгууллагууд, их дээд сургуулиуд, компаниуд, R&D байгууллагуудын нөлөөлөл.
- Судалгаа, технологийн шинэчлэлийн хамтын ажиллагааны сүлжээг дэмжих, бүрдүүлэх
- Бизнестэй холбоотой судалгааг явуулах харилцааг бий болгох
- Мэдлэг дамжуулахыг дэмжих хамтарсан төсөл боловсруулах
- Оролцогч талуудын хүртээмжийг хөнгөвчлөх зорилгоор лаборатори болон дундын тоног төхөөрөмж
- Хамтын нөөц ба хүчирхэг сүлжээний санаачлагуудын хамтын ажиллагаа

8. Төрийн дэмжлэг

- Засгийн газрын татаасаар өргөн хүрээтэй дэмжлэг үзүүлэх, голчлон эхний үе шатанд

- Бусад байгууллагуудаас илүү урт хугацаатай зээл, бага хүүтэй зээл олгох
- Түрээслэгчдийн урамшууллын хүрээг өргөжүүлэхийн тулд шинжлэх ухааны паркуудад туслах
- Паркийг төлөвлөх, хянах, хөгжүүлэх, зохицуулалт хийх, дэмжих
- Компаниудыг татахад орон нутгийн засаг захиргааны үүрэг оролцоог идэвхжүүлэх
- Бүс нутгийн эдийн засгийн сул талыг арилгах, хөгжлийг дэмжих бодлого, санал боловсруулах

9. Парк дизайны онцлог, тодорхойлолт

- Төслийн төрөл, хэмжээ, нарийн төвөгтэй байдал, нөөцийн хуваарилалт, байршуулалт гэх мэт.
- Төлөвлөлт, хяналт, багийн бүтэц, нэгдмэл байдал, гэрээний талууд
- Чухал үйл ажиллагаа, төсөв, эрсдэлийн менежментийг дэмжинэ
- Чанар, аюулгүй ажиллагааны хөтөлбөр, хуваарь, ажлын хуваарь
- Технологийн уялдаа холбоо, бүс нутгийн хөгжил, их сургууль, олон нийтийн харилцаа, сургалт, судалгаа, өргөтгөл зэрэг паркийн гол зорилтууд.
- Төслийн багийн ур чадвар: Туршлага, тууштай байдал, ажлын харилцаа, боловсролын түвшин, сургалт, шийдвэр гаргах үр дүнтэй байдал.
- Төслийг зохих төлөвлөлт, хяналт, оновчтой, тууштай удирдлагаар хэрэгжүүлэх; зөв тооцоолол, бодитой хүлээлт

Нийгэм эдийн засгийн үр нөлөө

Парк байгуулагдсанаар дараах нийгэм эдийн засгийн үр нөлөөг үзүүлнэ.

- Экспортод чиглэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэх
- Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах
- Бүс нутгийн хөгжилд ахиц дэвшил гарах
- Үндэсний компаниуд хүчин чадлаа нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа хөгжүүлэн олон улсын зах зээлд өрсөлдөх
- Шинэ ажлын байр бий болгох
- Мэргэшсэн ажилтны тоог нэмэгдэх зэрэг эдийн засгийн тусгаар тогтнол, аюулгүй байдал баталгаажих замаар Монгол Улсын эдийн засаг, нийгмийн амьдралд томоохон өөрчлөлт гарч, олон эерэг үр нөлөө бий болно.

Монгол Улсад шинжлэх ухаан, инновац, технологийн парк байгуулах нь эдийн засагт томоохон эерэг нөлөө үзүүлэх боломжтой. Тухайлбал, бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлийн хэмжээ, худалдааны эргэлт нь тодорхой хэмжээгээр нэмэгдэхийг таамаглах боломжтой бөгөөд энэ нь дараах хүчин зүйлсээс хамаарна:

1. Шинэ технологи нэвтрүүлэлт

Парк нь шинжлэх ухаан, технологийн шинэ шийдлүүдийг хөгжүүлж, үйлдвэрлэлд нэвтрүүлнэ. Энэ нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чанар, хүртээмжийг сайжруулах, мөн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг нэмэгдүүлэх болно. Жишээлбэл, хиймэл оюун ухаан, автоматжуулалт, робот техник зэрэг шинэ технологиуд нь үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний зардлыг бууруулахад тусална.

2. Эдийн засгийн өсөлт

Парк нь жижиг, дунд бизнесүүдийн хөгжлийг дэмжиж, эдийн засгийн өсөлтийг хурдасгана. Энэ нь худалдааны эргэлт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэхэд нөлөөлнө. Парк дахь компаниуд шинэ бүтээгдэхүүн гаргах, зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.

3.Хөрөнгө оруулалт ба санхүүжилт

Паркууд нь олон улсын болон дотоодын хөрөнгө оруулагчдыг татах боломжтой. Энэ нь шинэ бизнесүүдийн санхүүжилт, хөгжүүлэлтийг дэмжинэ. Хөрөнгө оруулалт нэмэгдэх нь худалдааны эргэлт, үйлдвэрлэлийн хэмжээний өсөлтөд эерэг нөлөө үзүүлнэ.

4.Бүтээгдэхүүн үйлчилгээний шинэчлэл

Парк нь шинэ үйлчилгээ, бүтээгдэхүүний зах зээлийг бий болгох, хөгжүүлэх боломжийг олгоно. Жишээлбэл, мэдээллийн технологийн салбарын шинэ үйлчилгээ, биотехнологи, эрүүл мэндийн бүтээгдэхүүнүүд үйлдвэрлэх нь зах зээл дээр шинэ боломжуудыг нээж, худалдааны эргэлт, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ.

5.Мэргэжилтнүүдийг татах

Парк нь чадварлаг мэргэжилтнүүдийг татах, тэдний мэдлэгийг ашиглах боломжийг бий болгож, олон шинэ төслүүдийн амжилттай хэрэгжүүлэлтэд хувь нэмэр оруулах болно. Үр дүнд нь бизнесийн шинэ загварууд бий болж, үйлдвэрлэлийн хэмжээ өсөх магадлалтай.

6.Гадаад зах зээлд гарах боломжууд

Парк нь экспортын боломжуудыг нээж, гадаад зах зээл рүү бүтээгдэхүүн экспортлох, худалдааны эргэлт нэмэгдүүлэх боломжийг олгоно. Олон улсын

хамтын ажиллагаа, экспортыг дэмжих нь Монголын бүтээгдэхүүнүүдийн гадаад зах зээл дээр амжилттай өрсөлдөх боломжийг бий болгоно.

Таамаглал

Монгол Улсад инновац, технологийн парк байгуулах нь 5-10 жилийн хугацаанд бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлийн хэмжээг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх боломжтой. Үүний зэрэгцээ, худалдааны эргэлт нь эдийн засгийн өсөлттэй хамт нэмэгдэх бөгөөд технологийн салбар дахь ажил эрхлэлт, хөрөнгө оруулалтын хэмжээ өснө.

Өөрөөр хэлбэл, энэ төрлийн парк нь технологи болон инновац шингэсэн шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрэх боломжийг олговол Монгол Улсын эдийн засаг, үйлдвэрлэлийн хэмжээ тодорхой хугацаанд өснө.

Шинжлэх ухаан, инновац, технологийн парк байгуулахад хөрөнгө оруулалт, дэд бүтэц, хамтын ажиллагаа зэрэг олон хүчин зүйлсийг харгалзан үзэх хэрэгтэй. Тиймээс бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлийн хэмжээ, худалдааны эргэлт зэрэг эдийн засгийн үзүүлэлтүүдийн өсөлт нь урт хугацаандаа өгөөжтэй гарах боломжтой.

Парк байгуулахад шаардлагатай хугацааг дараах байдлаар таамаглаж болно:

1. Богино хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны таамаглал (1-3 жил):

- **Шинэ санаа болон шинэ технологиудыг турших:** Эхний жилүүдэд парк нь шинэ санаа, шинэ технологийн туршилт, бүтээгдэхүүн хөгжүүлэлт дээр төвлөрөх хэрэгтэй. Энэ үед үйлдвэрлэлийн хэмжээ болон худалдааны эргэлт бага байж, шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд танилцуулах процессыг эхлүүлэхэд чиглэнэ.

- **Хөрөнгө оруулалт татах:** Үйлдвэрлэл эхлүүлэх, зарим бүтээгдэхүүнүүдийг зах зээлд гаргах, хөрөнгө оруулалтыг татах зэрэг процессууд явагдана.

2. Дунд хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны таамаглал (3-5 жил):

- **Бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэх:** Энэ хугацаанд парк дахь компаниуд үйл ажиллагаагаа өргөжүүлж, үйлдвэрлэлийн хэмжээ өсөх боломжтой. Инновац шингэсэн шинэлэг шийдлүүдийг зах зээлд амжилттай нэвтрүүлэх нь эдийн засагт шууд нөлөө үзүүлнэ.
- **Худалдааны эргэлт өсөх:** Парк дахь компаниуд экспортын боломжуудыг ашиглаж, олон улсын зах зээл рүү бүтээгдэхүүн гаргах боломжтой болно. Үүний үр дүнд худалдааны эргэлт нэмэгдэнэ.

3. Урт хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны таамаглал (5-10 жил):

- **Эдийн засгийн томоохон өөрчлөлт:** 5-10 жилийн дотор парк нь эдийн засгийн олон салбарт тодорхой үр дүнгээ үзүүлэх болно. Шинэ салбарууд бий болж, үйлдвэрлэлийн хэмжээ болон худалдааны эргэлт нь эдийн засгийн өсөлттэй уялдаатайгаар нэмэгдэнэ. Инновацийн төвүүд нь шинэ компаниудыг бойжуулан гаргаж, шинэ зах зээл бий болгоно.
- **Гадаад зах зээлд амжилттай өрсөлдөх:** Гадаад хөрөнгө оруулалт, экспортыг дэмжих үйл ажиллагаа эрчимжиж, Монгол Улсын бүтээгдэхүүнүүд олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай болж, худалдааны эргэлт нэмэгдэнэ.

Ерөнхий дүгнэлт:

- **1-3 жил:** Парк байгуулах, анхны бүтээгдэхүүнүүдийг гаргах, туршилт хийх хугацаа.
- **3-5 жил:** Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэх, худалдааны эргэлт өсөх хугацаа.
- **5-10 жил:** Эдийн засгийн үр дүн тодорхой гарах, экспорт, үйлдвэрлэлийн хэмжээ бодит өсөлттэй байх хугацаа гэж ойлгож болно.

Иймээс Монгол Улсад инновац, технологийн парк байгуулах нь эдийн засгийн томоохон өөрчлөлтүүдийг авчрах бөгөөд 5-10 жилийн хугацаанд тодорхой хэмжээнд өсөлт харагдах боломжтой.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны хүрээнд Монгол улсад шинжлэх ухаан, технологи, инновацын парк байгуулах чиглэлээр хууль эрх зүйн орчин, олон улсын паркуудын туршлага, эрдэмтдийн гаргасан нийтлэл судалгаа, шинжилгээний ажил, нийтлэл, зөвлөмжүүдийг судлан дараах дүгнэлтүүдийг хийж байна.

Уул уурхайд түшиглэсэн эдийн засгийн бүтэцтэй манай оронд эдийн засгийн төрөлжилт бий болгох, бүс, орон нутгийн хөгжлийг эрчимжүүлэхийн тулд олон улсад тогтсон хамгийн үр ашигтай дэд бүтцийн хэлбэр болох шинжлэх ухаан, технологи, инновацын паркийг байгуулах зүйтэй юм.

Түүнчлэн хэрэглэгч цөөхөнтэй дотоодын зах зээлээс дэлхийн зах зээлд хэрэглэгчийн нарийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, ухаалаг, инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь манай улсын хувьд чухал

зорилт болж байна. Стартапууд олноор гарч ирж байна. Мөн энтрепернершипийн орчинд эерэг нөлөөллүүд гарч байна. Хөрөнгө оруулагчид, тэр дундаа гадаад, дотоодын “анжел” хөрөнгө оруулагчид стартапуудыг ихээр сонирхож байна.

Парк нь эдийн засгийн хөгжлийн гол хэрэгсэл болохын ач холбогдлыг өндөр хөгжилтэй орнууд сүүлийн гучин жилийн хугацаанд мэдэрсэн бөгөөд хөгжиж буй эдийн засагтай орнууд ч шинжлэх ухааны паркийн төслүүдийг төлөвлөж, хэрэгжүүлж байна.

Гэхдээ төлөвлөлтийн хувьд шинжлэх ухааны паркууд нь дэлхийн нийтийн зөвшилцлийн объект биш, учир нь өөр өөр бүс нутаг, улс орнуудад ижил төстэй стандартаар төлөвлөж болох зочид буудал, рестораны сүлжээнээс ялгаатай нь паркуудад хамгийн сайн тохирох дэлхийн нэгдсэн стандарт байдаггүй.

Эцэст нь дүгнэхэд Монгол улсад паркийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттайгаар Засгийн газрын идэвхтэй санаачлага, дэмжлэгээр бий болгох боломжтой байна.

Бидний хийсэн тооцооллоор парк байгуулах хувийн хэвшлийн зүгээс 30 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, жилийн 1 тэрбум орчим төгрөгийн урсгал зардлыг гарган нийт 40 хүний орон тоотойгоор ажиллан 100-300 хүнтэй 50-100 гарааны бизнесийг хөгжүүлэн ажиллах бололцоотой байна.

Засгийн газрын зүгээс паркийн газрын асуудлыг шийдвэрлэх, газрын төлбөрийг хариуцан төлөх, зарим ажилтны цалин хөлс урсгал зардлыг хариуцах зэргээр хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх боломжтой.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ, МАТЕРИАЛ**НЭГ. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ТУЛГУУР БАРИМТ БИЧГҮҮД:**

1. Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг Алсын хараа 2050;
2. “Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги (2010 он хүртэл)”, Бүс нутгийн удирдлага, төлөвлөлт ном. УБ, 2003. хууд 51-120;
3. “Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр” 2009 он;
4. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр, 2024 он;

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИУД:

1. Инновацийн тухай хууль, 2012 он;
2. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, 2022 он;

ГУРАВ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАНГУУД:

1. Азийн хөгжлийн банк, “Монгол улсын эдийн засгийн хэтийн төлөв”, 2020 он;
2. Үндэсний статистикийн хороо, Монгол Улсын нийгэм эдийн засгийн байдал, 2024/IV судалгааны тайлан;
3. Парламентийн судалгаа хөгжлийн хүрээлэн, Судалгааны эмхэтгэл, Боть 48, 2024 он